



МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДАРГА САНДАГИЙН
БЯМБАЦОГТ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2026.04.20 № 3Г-1/31
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн
мэдүүлэх тухай

Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэхийг хүсье.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Н.УЧРАЛ

000264001503



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn


2026.03.13 № ХЭГ/829
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай

Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлохыг хүсье.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



С.БЯМБАЦОГТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 2 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“8.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн дэмжээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: http://www.mof.gov.mn


2026.02.16 № 01/994
танай 2026.02.04 ны № 1а/461 -Т

**БАТЛАН ХАМГААЛАХЫН
САЙД Д.БАТЛУТ ТАНАА**

Таны ирүүлсэн Улсын нисэхийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн төсөл болон дагалдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл хүсэх тухай албан бичигтэй танилцлаа.

Дээрх хуулийн төсөлд Сангийн яамнаас хүргүүлсэн санал тусгагдсанаас гадна уг хуулийн төсөл батлагдсанаар төсөвт нэмэлт ачаалал үүсгэхгүйгээр одоогийн орон тоо бүтэц, батлагдсан төсөвт багтаан хэрэгжүүлэх хүрээнд Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг зөвшөөрч байна.

Хүндэтгэсэн,



Б.ЖАВХЛАН

9761000301



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2026.02.10 № 1/767

танай 2026.02.04 -ны № 1а/460 -т

**БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД
Д.БАТЛУТ ТАНАА**



Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон түүнийг дагалдуулан боловсруулсан зарим хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



Б.ЭНХБАЯР

ХЗДХЯ-ны А5

152640299



УЛСЫН НИСЭХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван нэгдүгээр зүйлийн 1-д “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн” гэж, мөн зүйлийн 2-т “Монгол Улс өөрийгөө хамгаалах зэвсэгт хүчинтэй байна. Зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалт, түүнд алба хаах журмыг хуулиар тогтооно” гэж тус тус заасан. Түүнчлэн Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 6-д “улсыг батлан хамгаалах хүчин чадлыг бэхжүүлж, үндэсний аюулгүй байдлыг хангах” тухай заасан нь батлан хамгаалах болон нисэхийн чиглэлээр төрөөс эрх зүйн зохицуулалт хийх үндэс суурийг бүрдүүлж байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилт 5.2-т төрийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тодорхойлж, чиг үүрэг, эрх мэдлийн хуваарилалтыг нарийвчлах тухай заасан. Мөн Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс”-ийн 6.2-т батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны харилцааг зохицуулах эрх зүйн цогц байдлыг бүрдүүлэх талаар, Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 4.1.3-т үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж, ажил үүргийн давхцал, хийдлийг арилгах, харилцан зохицуулалт хийх механизмыг боловсронгуй болгох талаар тус тус заасан нь Улсын нисэхийн чиглэлээр шинэ зохицуулалт хийх шаардлагыг тодорхойлж байна.

Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 74-т улсын агаарын хөлөг эзэмшигч төрийн цэргийн байгууллагын үйл ажиллагааг нэгдсэн бодлого, удирдамжаар хангах, хяналт тавих зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зохицуулалтыг тодорхой болгох, мөн хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилган хуулийг боловсронгуй болгохоор Улсын нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, 2025 онд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тусгасан.

Хуулийн төсөл боловсруулах явцад Улсын нисэхийн тухай хуулийн нийт заалтын 50-иас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орох нөхцөл байдал үүссэн тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2-т заасны дагуу хуулийн төслийг шинэчилсэн найруулгаар боловсруулах нь зүйтэй байна.

Улсын нисэхийн салбарт төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх, улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагуудын тоо нэмэгдэж, гүйцэтгэх үүргийн цар хүрээ, оролцоо өргөжсөнтэй уялдуулан Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 486 дугаар тогтоолоор Улсын нисэхийн асуудал хариуцсан бүтцийн нэгжийг Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад шилжүүлэн байгуулсан. Иймд Улсын нисэхийн хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгийн уялдаа холбоог сайжруулах, хуулийн хийдэл, давхардал, зөрчлийг арилгах, улсын агаарын хөлгөөр нислэг үйлдэх, түүний аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлыг хангах, улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагын албан хаагчдад тавих мэргэжлийн шалгуур үзүүлэлт, шаардлага, хариуцлагыг өндөржүүлэх, эрх зүйн баталгааг бүрдүүлэх, мөн Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Иргэний нисэхийн тухай хуулиуд шинэчлэн батлагдсантай нийцүүлэн Улсын нисэхийн тухай хуулийн төслийг шинэчлэн найруулах зайлшгүй шаардлага үүссэн болно.

Улсын нисэхийн хуулийг анх Улсын Их Хурал 2003 онд баталж, нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, хууль тогтоомжийн шинэчлэлд нийцүүлэн 2004, 2013, 2015, 2018, 2023 онуудад тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан. Гэвч цаг үеийн шинэ шаардлага, төрийн чиг үүргийн зохион байгуулалтын өөрчлөлт, холбогдох хуулиудтай уялдуулах шаардлага урган гараад байна.

1.2. Практик хэрэгцээ, шаардлага

Сүүлийн жилүүдэд Улсын нисэхийн тухай хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд (Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлал, Онцгой байдлын ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар)-ыг улсын агаарын хөлгөөр хангаж, хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр Засгийн газраас бодлогоор дэмжиж ажиллаж байна. Тухайлбал, 2020 оноос хойш Зэвсэгт хүчний Агаарын цэрэг 7, Хил хамгаалах ерөнхий газар 1, Онцгой байдлын ерөнхий газар 4 нэгж агаарын хөлгөөр хүчин чадлаа нэмэгдүүлжээ.

Улсын нисэхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, холбогдох хууль тогтоомжтой нийцүүлэн боловсронгуй болгож, зарим эрх зүйн харилцааг илүү тодорхой болгох практик хэрэгцээ дараах байдлаар үүсээд байна. Үүнд:

1. Монгол Улсын Үндсэн хууль болон Засгийн газрын тухай хуульд улсын агаарын хөлөг эзэмшигч байгууллагын үйл ажиллагааг тусгайлан зохицуулаагүй тул хуулийн төслөөр Улсын Их Хурал болон Засгийн газрын бүрэн эрхийн хүрээнд зохицуулалт хийж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах шаардлагатай.

2. Улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагууд сүүлийн жилүүдэд шинэ төрлийн хөлөг нэвтрүүлж, олон улсын гэрчилгээтэй гадаад, дотоодын байгууллага, иргэдтэй хамтран ажиллах болсонтой уялдуулан тусгайлсан эрх зүйн зохицуулалт шаардлагатай болсон.

3. Улсын нисэхийн асуудал хариуцсан нэгжийг Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад шинээр байгуулсан тул агаарын хөлгийн бүртгэл, нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгох, сунгах, цуцлах, инженер, техникчид, нисгэгчдэд мэргэжлийн үнэмлэх, зэрэглэл олгох, батламжлах, даатгалын харилцааг зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлага бий болсон.

Жишээлбэл, Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлал нь Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Мюнхен хотын "AIRBUS Helicopters" компанид

үйлдвэрлэгдсэн H145/MBB-BK117 D-3 загварын дунд оврын, хос хөдөлгүүртэй нисдэг тэргийг нэвтрүүлсэн. Тус хөлгийг тусгай болон онцгой үүргийн нислэгт ашиглах бөгөөд түүнийг даатгалд хамруулах эрх зүйн зохицуулалт одоогийн хуульд тусгагдаагүй байна.

4.Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуульд нислэгийг “байлдааны үүргийн нислэг”, “онцгой үүргийн нислэг”, “тусгай үүргийн нислэг”, “арилжааны нислэг”, “сургууль-байлдааны нислэг”, “шалгалт, туршилтын нислэг” гэж ангилдаг. Харин практикт “сургууль-дадлага”, “олон улсын”, “албан захиалгат” зэрэг нислэгийн төрөл шинээр үүсч, эрх зүйн зохицуулалт шаардагдах болсон.

Жишээлбэл, хил хамгаалах болон онцгой байдлын байгууллагын нислэг нь “сургууль-байлдааны” бус “сургууль-дадлага”-ын шинжтэй, мөн төрийн байгууллагууд арилжааны нислэг хийх эрхгүй тул “албан захиалгат” нислэг хийх хэрэгцээ байна. Олон улсын сургууль, энхийг сахиулах ажиллагаа зэрэг шинэ нөхцөлд “олон улсын нислэг” гэсэн ангилал шаардлагатай болсон.

Иймд дээрх хууль зүйн болон практик шаардлагад нийцүүлэн Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах нь зүйтэй. Ингэснээр хуулийн зохицуулалт тодорхой болж, хэрэглэхэд ойлгомжтой болохын зэрэгцээ давхардал, хийдэл арилж, хууль хэрэгжүүлэх эрх зүйн орчны үндэс сайжрах юм.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд дараах асуудлыг тусгаж байна. Үүнд:

1.Хуулийн нийтлэг үндэслэлийг тодорхойлсон харилцааг тусгаж, хуулийн зорилт, улсын нисэхийн тухай хууль тогтоомж, үйлчлэх хүрээнд улсын нисэхийн үйл ажиллагааны үндсэн зарчим болон нэр томъёоны талаарх зохицуулалтыг;

2.Улсын нисэхийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг;

3.Улсын нисэхийн үйл ажиллагааны зохицуулалтын талаарх эрх зүйн харилцааг;

4.Улсын агаарын хөлөг, түүнд хамаарах үйл ажиллагааг зохицуулахтай холбогдсон харилцааг;

5.Улсын нисэхийн аэродромын ашиглалттай холбогдсон харилцааг;

6.Нислэгийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалтыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг;

7.Улсын агаарын хөлгийг эрэн хайх, авран туслах, үйл ажиллагаатай холбогдсон эрх зүйн харилцааг;

8.Улсын нисэхийн нислэг-техникийн осол зөрчлийг шинжлэн шалгахтай холбогдсон эрх зүйн харилцааг;

9.Улсын нисэхийн үйл ажиллагаанд хууль зөрчигчид хариуцлага хүлээлгэхтэй холбогдсон харилцааг тус тус тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар дараах үр дүнд хүрнэ гэж үзэж байна. Үүнд:

Улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагын нислэг үйлдэх болон нислэгийн үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчин сайжирна;

Улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагын улсын агаарын хөлгөөр нислэг үйлдэх, нислэг, нислэгийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг зааж өгснөөр хяналт, хариуцлага сайжирч, хүлээх үүрэг тодорхой болно;

Улсын нисэхийн эрх зүйн орчныг боловсронгуй болгож, улсын нисэхийн үйл ажиллагаанд оролцогч иргэн, аж ахуйн нэгж, төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллагын нисэхийн аюулгүй байдалтай холбоотой хүлээх үүрэг, хариуцлага дээшилнэ;

Улсын нисэхийн тухай хуулийн зөрчил, ойлгомжгүй, тодорхойгүй зохицуулалтуудын давхардал, хийдэл арилж, зохицуулалтгүй байгаа болон ирээдүйд үүсэж болох харилцааг зохицуулах эрх зүйн орчин сайжирч, үр нөлөө дээшилнэ;

Улсын нисэхийн тухай хуулийн шинэчлэл, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон төсөвт ямар нэгэн нэмэгдэл зардал үүсэхгүй болно;

Улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагууд нислэгийн үйл ажиллагаа хууль, дүрэм, журам, зааврын хүрээнд явуулах, нислэгийн осол, зөрчил гарах нөхцөлийг бууруулах боломж бүрдэнэ.

Иймд хуулийн шинэчилсэн найруулга батлагдсанаар нэмэлт төсөв шаардахгүй бөгөөд эрх зүйн зохицуулалтын үр нөлөө мэдэгдэхүйц сайжирна.

Дөрөв.Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаар

Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, холбогдох бусад хуультай уялдуулан боловсруулна.

Мөн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбоотойгоор одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй “Улсын нисэхийн тухай хууль”-ийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Зэвсэгт хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус хамтад нь боловсруулна.

УЛСЫН НИСЭХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”- ийн 74-т “Улсын нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг боловсруулж, хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэж заасны хэрэгжилтийг хангах хүрээнд Улсын нисэхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төслийг боловсруулсан.

Батлан хамгаалахын сайдын 2025 оны А/12 дугаар тушаалаар Улсын нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэг байгуулан, хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, үнэлгээний тайланг хийхэд Хууль тогтоомжийн тухай хуулийн 25.1.2- т заасны дагуу тус хуулийн нийт заалтын 50-аас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орох нөхцөл үүссэн тул хуулийн төслийг шинэчилсэн найруулгын хэлбэрээр боловсруулсан болно.

Тус хуулийн төслийг боловсруулахдаа сүүлийн жилүүдэд Улсын нисэхийн тухай хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудад улсын агаарын хөлөг шинээр авч ашиглах үйл ажиллагааны цар хүрээ улам нэмэгдэж байгаатай холбогдуулан улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагуудын үйл ажиллагааг нэгдсэн бодлого, удирдлагаар хангах, тэдгээрийн чиг үүргийг хуулиар тодорхойлох, улсын нисэхийн багц дүрмээр зохицуулах харилцааг нарийвчлан заах, улсын агаарын хөлгийг бүртгэх, нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгох, гадаадын иргэн гэрээгээр үүрэг гүйцэтгэх болон улсын нисэхийн аюулгүй байдал, нислэгийн үйл ажиллагааны хяналт, зохицуулалтын талаарх эрх зүйн зохицуулалтыг өөрчлөх, боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлагад нийцүүлсэн.

Түүнчлэн улсын нисэхийн асуудлыг удирдан чиглүүлэх асуудлын хүрээнд Улсын Их Хурал, Засгийн газрын бүрэн эрх болон Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, цэргийн мэргэжлийн удирдлагын дээд байгууллага, улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагуудын чиг үүргийг нарийвчлан тодорхойлсноороо Улсын нисэхийн тухай хууль /шинэчлэн найруулга/-ийн төсөл хүчин төгөлдөр мөрдөж буй хуулиас онцлогтой болсон.

Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар улсын төсөвт нэмэлт зардал шаардахгүй бөгөөд хууль, эрх зүйн зохицуулалтын үр нөлөө сайжирч, улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагын нислэгийн үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн орчин сайжирч, улсын нисэхийн үйл ажиллагаанд оролцогч иргэн, аж ахуйн нэгж, төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллагын хүлээх үүрэг, хариуцлага, хяналт, зохицуулалт тодорхой болж, түүнийг дагалдан хуулийг хэрэгжүүлэх бусад эрх зүйн баримт бичгүүд боловсронгуй болох, хуулийн давхардал, хийдэл, зөрчил арилах зэрэг чухал ач холбогдолтой юм.

Хуулийн төсөлд төрийн захиргааны төв байгууллагууд болон төрийн бус байгууллага, хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд болон цахим санал, хэлэлцүүлэг зохион байгуулахад бүгд дэмжсэн болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

УЛСЫН НИСЭХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Улсын нисэхийн тухай хууль нь 2003 онд анх батлагдаж улсын агаарын хөлгөөр нислэг үйлдэх, улсын нисэхийн аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулж байна. Тус хуульд нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, бусад хууль тогтоомжид нийцүүлэх шаардлагын үүднээс нийт 6 удаа холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 74-т “Улсын нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг боловсруулж, 2025 онд хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх гэж заасныг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Улсын нисэхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төслийн боловсруулан, хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д заасны дагуу төрийн захиргааны төв байгууллагуудын саналыг тусган боловсрууллаа.

Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг хангах хүрээнд Батлан хамгаалахын сайдын 2025 оны А/12 дугаар тушаалаар Улсын нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах чиг үүрэг бүхий “Ажлын хэсэг”-ийг байгуулан, хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, үнэлгээний тайланг хийхэд Хууль тогтоомжийн тухай хуулийн 25.1.2-т заасны дагуу тус хуулийн нийт заалтын 50-аас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орох нөхцөл үүссэн тул “Ажлын хэсэг”-ээс хуулийн төслийг шинэчилсэн найруулгын хэлбэрээр боловсруулах нь зүйтэй гэж үзсэн болно.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа–2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн тавдугаар зүйлийн зорилт 5.2-т төрийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тодорхойлж, чиг үүрэг, эрх мэдлийн хуваарилалтыг нарийвчлах тухай, мөн 2015 оны 85 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс”-т батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны харилцааг зохицуулах эрх зүйн цогц байдлыг бүрдүүлэх талаар, 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж, ажил үүргийн давхцал, хийдлийг арилгах, харилцан зохицуулалт хийх механизмыг боловсронгуй болгох талаар тус тус заасан нь Улсын нисэхийн чиглэлээр шинэ зохицуулалт хийх шаардлагыг тодорхойлж байна.

Тус хуулийн төслийг боловсруулахдаа сүүлийн жилүүдэд Улсын нисэхийн тухай хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудад улсын агаарын хөлөг шинээр авч ашиглах үйл ажиллагааны цар хүрээ улам нэмэгдэж байгаатай холбогдуулан улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагуудын үйл ажиллагааг нэгдсэн бодлого, удирдлагаар хангах, тэдгээрийн чиг үүргийг хуулиар тодорхойлох, улсын нисэхийн багц дүрмээр зохицуулах харилцааг нарийвчлан заах, улсын агаарын хөлгийг бүртгэх, нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгох, гадаадын иргэн гэрээгээр үүрэг гүйцэтгэх болон улсын нисэхийн аюулгүй байдал, нислэгийн үйл ажиллагааны хяналт, зохицуулалтын талаарх эрх зүйн зохицуулалтыг өөрчлөх, боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлагад нийцүүлсэн.

Түүнчлэн улсын нисэхийн асуудлыг удирдан чиглүүлэх асуудлын хүрээнд Улсын Их Хурал, Засгийн газрын бүрэн эрх болон Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, цэргийн мэргэжлийн удирдлагын дээд байгууллага, улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагуудын чиг үүргийг нарийвчлан тодорхойлсноороо Улсын нисэхийн тухай хууль /шинэчлэн найруулга/-ийн төсөл хүчин төгөлдөр мөрдөж буй хуулиас онцлогтой болсон.

Хуулийн төсөлд улсын нисэхийн асуудлыг удирдан чиглүүлэх асуудлын хүрээнд Улсын Их Хурал, Засгийн газрын бүрэн эрх, Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, цэргийн мэргэжлийн удирдлагын дээд байгууллага болон Улсын нисэхийн үйл ажиллагаа эрхлэгч болон Улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагуудын үүрэг, чиглэлийг хуулийн төсөлд нарийвчлан тусгалаа.

Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд шинэчлэн найруулсан болон нэмэгдүүлсэн зүйл заалтуудыг бүлэг бүрээр тусгавал дараах байдалтай байна. Үүнд:

1. Нэгдүгээр бүлэг – Нийтлэг үндэслэл. Хүчин төгөлдөр хуулийн 1 дүгээр бүлгийн 4 зүйл, 6 хэсэг, 5 заалтыг өөрчилж найруулан 4 зүйл, 6 хэсэг, 18 заалттайгаар боловсруулсан.

Утга найруулгын өөрчлөлтүүд болон хуулийн нэр томъёонд нэмэлтээр улсын агаарын хөлгөөр үйлдэх нислэгийн ангиллууд, улсын нисэхийн багц дүрэм, улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллага болон цэргийн зориулалттай нисгэгчгүй нисэх хэрэгсэл зэрэг тодорхойлолтуудыг тусгасан.

2. Хоёрдугаар бүлэг – Улсын нисэхийн талаарх төрийн байгууллагын бүрэн эрх. Хүчин төгөлдөр хуулийн 3 зүйл, 4 хэсэг, 15 заалтыг өөрчилж 6 зүйл, 9 хэсэг, 31 заалттай байхаар шинэчлэн боловсруулсан.

Тус бүлэгт Улсын их хурлын бүрэн эрх, Засгийн газрын бүрэн эрх, Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагуудын чиг үүргийг шинээр, Батлан хамгаалах асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүний бүрэн эрх, Цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллагын чиг үүргийг шинэчлэн найруулж улсын нисэхийн үйл ажиллагааг төрөөс зохицуулах нарийвчилсан зохицуулалтуудыг тусгаж өгсөн. Мөн хүчин төгөлдөр хуулийн 2 дугаар бүлэгт тусгагдсан байсан улсын нисэхийн багц дүрмийн зохицуулалтыг тус бүлгээс хассан.

3. Гуравдугаар бүлэг – Улсын нисэхийн үйл ажиллагааны зохицуулалт. Хүчин төгөлдөр хуулийн 2 дугаар бүлэгт тусгагдсан байсан улсын нисэхийн багц дүрмийн зохицуулалтыг шинээр бүлэг болгон боловсруулж 1 зүйл, 1 хэсэг, 8 заалтыг өөрчлөн найруулан 1 зүйл, 1 хэсэг, 11 заалт байхаар тусгасан.

Энэ бүлэгт тусгагдсан үйл ажиллагааны зохицуулалт нь тус хуультай нийцүүлэн баталсан эрх зүйн хэм, хэмжээний акт болох “Улсын нисэхийн багц дүрэм”-ийн харилцааг хуульчилсан байх ба шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар одоо байгаа 7 дүрэм болон нэмэлтээр “Улсын агаарын хөлгөөр нислэг үйлдэх дүрэм”, “Нисэхийн инженерийн албаны дүрэм”, “Нислэгийн дадлагажуурын цогцолборыг ашиглах дүрэм” болон “Цэргийн зориулалттай нисгэгчгүй нисэх хэрэгслийг бүртгэх, гэрчилгээжүүлэх, ашиглах, хяналт тавих

дүрэм”-үүд улсын нисэхийн үйл ажиллагааг зохицуулах үндсэн баримт бичгүүд байхаар тус хуулийн төсөлд тусгагдаад байна.

4. Дөрөвдүгээр бүлэг – Улсын агаарын хөлөг, түүнд хамаарах үйл ажиллагаа. Хүчин төгөлдөр хуулийн 4 зүйл, 14 хэсэг, 8 заалтыг өөрчилж 4 зүйл, 22 хэсэг, 8 заалттайгаар боловсруулсан.

Тус бүлэгт Улсын агаарын хөлгийн бүртгэл, гэрчилгээжүүлэх үйл ажиллагаа, Улсын агаарын хөлгөөр үйлдэх нислэгийн ангилал, нислэгийн хөдөлгөөнийг зохицуулахтай холбогдсон зарим харилцаануудыг илүү тодорхой байдлаар хуульчлах зорилтын хүрээнд нарийвчилсан зохицуулалтууд нэмэлтээр болон шинэчлэн найруулагдсан. Мөн энэ бүлэгт улсын агаарын хөлгөөр нислэг үйлдэх, техник үйлчилгээ хийх нисгэгч, инженер техникчдийн бүрэлдэхүүнд шаардлага хангаж буй гадаад улсын болон монгол улсын иргэнийг гэрээгээр үүрэг гүйцэтгүүлэх боломжийг нээж тодорхой зохицуулалт тусгагдсан.

5. Тавдугаар бүлэг – Улсын нисэхийн аэродромын ашиглалт. Тухайн бүлэг нь хүчин төгөлдөр байгаа улсын нисэхийн тухай хуулийн 2 зүйл, 6 хэсэгт өөрчлөлт оруулж 2 зүйл 9 хэсэг байхаар боловсруулагдсан.

Хуулийн төсөлд улсын нисэхийн аэродромыг байгуулах, бүртгүүлэх, түүнтэй холбоотой үйл ажиллагааг нарийвчлан тодорхойлохоор шинэчлэн найруулсан. Мөн улсын нисэхийн аэродромын аюулгүй байдал, ашиглалт, хамгаалалт, бэлэн байдал, тоноглолыг улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллага хариуцахаар шинээр зохицуулалт тусгагдсан. Түүнчлэн хүчин төгөлдөр хуульд улсын нисэхийн аэродромыг хамтран ашиглах тухай зохицуулалт байсан бол шинэчилсэн найруулгын төсөлд эзэмшил хамаарахгүйгээр улсын болон иргэний нисэхийн аэродромыг хамтран ашиглах тухай асуудал журмаар зохицуулагдах зохицуулалт тусгагдсан.

6. Зургаадугаар бүлэг – Нислэгийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалт. Улсын нисэхийн тухай хуулийн 1 зүйл 7 хэсгийг 2 зүйл, 6 хэсэг, 6 заалттай байхаар боловсруулсан.

Тус бүлэгт улсын нисэхийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдалтай холбоотой зохицуулалтууд байсныг Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон бусад хууль, тогтоомжуудтай нийцүүлэн нэршлийг нислэгийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалт болгон өөрчлөн найруулсан. Хүчин төгөлдөр хуульд нислэгийн аюулгүй байдлын хяналтын зохицуулалтууд тодорхой тусгагдаагүй байсныг нарийвчилж, батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын улсын хяналтын байцаагч (улсын нисэхийн байцаагч нисгэгч, инженер)-ын эрх, үүргийг иргэний нисэхийн хяналтын байцаагчидтай дүйцүүлэн тусгасан. Мөн хүчин төгөлдөр буй хуульд тусгагдсан аюулгүйн хамгаалалттай холбоотой зохицуулалтуудыг шинэчлэн найруулж өөрчилсөн.

7. Долдугаар бүлэг – Улсын агаарын хөлгийг эрэн хайх аврах ажиллагаа. Хуулийн 3 зүйл, 5 хэсгийг өөрчлөн найруулж 2 зүйл 5 хэсэгтэй байхаар боловсруулсан.

Тус бүлэгт тусгагдсан байсан эрэн хайх авран туслах ажлын зохицуулалтуудыг гамшгийн тухай хууль болон бусад хуулиудтай нийцүүлж холбогдох найруулгуудыг

боловсруулсан. Мөн энэ чиглэлээр дүрмийн зохицуулалттай байх зорилгоор улсын нисэхийн багц дүрмээр зохицуулах тухай хэсэг нэмсэн.

8. Наймдугаар бүлэг – Улсын нисэхийн нислэг-техникийн осол зөрчлийг шинжлэн шалгах. Энэ бүлэг нь хүчин төгөлдөр буй хуулийн 2 зүйл 4 хэсэг, 5 заалтад өөрчлөлт оруулж 3 зүйл, 8 хэсэг, 17 заалттайгаар шинээр боловсруулагдсан.

Энэ бүлэг нь бүтцийн хувьд улсын нисэхийн нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах болон улсын нисэхийн нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах шинжээчийн бүрэн эрхийн асуудлуудыг тусгасан байсныг осол зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаа, ерөнхий шинжээчийн бүрэн эрх, үүрэг, шинжлэн шалгах комисс, түүний бүрэн эрх гэсэн байдлаар илүү системтэй ойлгомжтой байдлаар боловсруулсан. Улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шалгах шинжээч болон комиссын бүрэн эрхийг Иргэний нисэхийн тухай хуульд энэ чиглэлээр тусгагдсан зарим зохицуулалтуудтай дүйлгэж шинээр боловсруулсан. Мөн шинжээч болон комиссын үйл ажиллагааг хараат бус, бие даасан байлгах үндсийг тус хуулийн зохицуулалтаар бий болгож байгаа нь онцлог юм. Түүнчлэн Улсын нисэхийн нислэг-техникийн осол зөрчлийг шалгах шинжээч, комиссын бүрэлдэхүүнд тавигдах шаардлага, ажиллах чиг үүргийг тодорхой зааж өгсөн.

9. Есдүгээр бүлэг – Бусад зүйл. Тус бүлгийн 1 зүйл 2 хэсгийг бусад хууль, тогтоомжуудтай нийцүүлэн найруулгын өөрчлөлтийг тусган өөрчилсөн. Мөн хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл гэм хэргийн шинжгүй бол төрийн албаны тухай хуулиас гадна цэргийн албаны тухай хуульд заасан хариуцлагыг хүлээлгэх зохицуулалтыг нэмсэн.

Ийнхүү Улсын нисэхийн тухай хуулийг одоогийн нөхцөл, бусад хууль тогтоомжтой нийцүүлэн 9 бүлэг, 25 зүйл, 68 хэсэг, 91 заалттайгаар эцэслэн боловсруулагдсан болно.

Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар улсын төсөвт нэмэлт зардал шаардахгүй бөгөөд хууль, эрх зүйн зохицуулалтын үр нөлөө сайжирч, улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагын нислэгийн үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн орчин сайжирч, улсын нисэхийн үйл ажиллагаанд оролцогч иргэн, аж ахуйн нэгж, төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллагын хүлээх үүрэг, хариуцлага, хяналт, зохицуулалт тодорхой болж, түүнийг дагалдан хуулийг хэрэгжүүлэх бусад эрх зүйн баримт бичгүүд боловсронгуй болох, хуулийн давхардал, хийдэл, зөрчил арилах зэрэг чухал ач холбогдолтой юм.

Хуулийн төсөлд төрийн захиргааны төв байгууллагууд болон төрийн бус байгууллага, хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд болон цахим санал, хэлэлцүүлгийг зохион байгуулж явуулахад хуулийн төслийг бүгд дэмжсэн болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

УЛСЫН НИСЭХИЙН ТУХАЙ (Шинэчилсэн найруулга)

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилго

1.1. Энэ хуулийн зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэр, агаарын зайд улсын агаарын хөлгөөр нислэг үйлдэх, улсын нисэхийн үйл ажиллагааны удирдлага, зохицуулалт, нисэхийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Улсын нисэхийн тухай хууль тогтоомж

2.1.Улсын нисэхийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хуулиар дараах харилцааг зохицуулна:

3.1.1.улсын нисэхийн үйл ажиллагаа, түүнд хамаарах улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагуудын нислэг;

3.1.2.улсын агаарын хөлгийн нислэгийн хөдөлгөөнийг удирдахтай холбогдсон харилцаа.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёо

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“аюул тулгарсан агаарын хөлөг” гэж агаарын хөлөг болон зорчигчдод аюул учирч, түүнийг нисэх баг өөрийн үйл ажиллагаагаар арилгаж чадахгүйд хүрсэн, эсхүл агаарын хөлөг холбоогүй буюу байрлал нь тодорхой бус болсон;

4.1.2.“аюулд нэрвэгдсэн агаарын хөлөг” гэж агаарын хөлөг болон зорчигчдод аюул учирч, нислэгийн явгалалт, хөөрөлт, буулт, нислэгийн үед гэмтэж аргагүйдсэн буулт үйлдсэн эсхүл бүрэн эвдэрсэн;

4.1.3.“байлдааны агаарын хөлөг” гэж байлдаанд ашиглах зориулалтаар зэвсэг, галт хэрэгсэл, тусгай төхөөрөмжөөр тоноглогдсон агаарын хөлгийг;

4.1.4.“байлдааны үүргийн нислэг” гэж байлдааны үүрэг, байлдааны жижүүрлэлт болон Монгол Улсын агаарын зайн аюулгүй байдлыг хангах ажиллагааны нислэгийг;

4.1.5.“захиалгат нислэг” гэж гамшиг ослын болон бусад үед яаралтай хүний амь нас, эрүүл мэндийг аврах болон тусгай үүрэг гүйцэтгэх чиглэлээр иргэн, хуулийн этгээдийн хүсэлтээр үйлдэх нислэгийг;

4.1.6.“онцгой үүргийн нислэг” гэж Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.2, 6.1.6, 6.1.7-д заасан этгээдэд үйлчлэх нислэгийг;

4.1.7. “олон улсын нислэг” гэж энэ хуулийн 14.1.1, 14.1.6-д зааснаас бусад олон улсад үйлдэх нислэгийг;

4.1.8.“сургууль-байлдааны нислэг” гэж бүх төрлийн буудлага, бөмбөгдөлт, пуужингийн харвалттай нислэг болон олон улсын хээрийн сургууль дадлагын нислэгийг;

4.1.9.“сургууль-дадлагын нислэг” гэж олон улсын сургууль, хамтарсан болон бие даасан бүх төрлийн дадлага сургалт, эрх олгох нислэгийг;

4.1.10.“тусгай үүргийн нислэг” гэж тайван цагийн батлан хамгаалах нислэг, хил хамгаалалт, хилийн эрэл, тусгай ажиллагаа, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, гамшиг, осол, эрэн хайх, аврах ажиллагаа, эмнэлгийн яаралтай түргэн тусламж болон төрийн чиг үүргийг гүйцэтгэх байгууллагуудын ажил, үүргийг гүйцэтгэх нислэгийг;

4.1.11. “улсын агаарын хөлөг” гэж төрийн цэргийн болон төрийн бусад чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллагын агаарын хөлгийг;

4.1.12.“улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллага” гэж төрийн цэргийн болон төрийн бусад чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллагыг;

4.1.13.“улсын нисэх” гэж улсын агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэхтэй холбогдсон цогцолбор ойлголтыг;

4.1.14.“цэргийн зориулалттай нисгэгчгүй нисэх хэрэгсэл” гэж Зэвсэгт хүчний тухай хуулийн 3.1.10-т заасан ажиллагаанд ашиглагдах алсаас удирдлагатай, эсхүл автомат удирдлагатай нисгэгчгүй нисэх хэрэгсэл (дрон)-ийг;

4.1.15.“шалгалт, туршилтын нислэг” гэж агаарын хөлгийг агаар болон газарт шалгах, засвар, техникийн үйлчилгээ, тоног төхөөрөмж суурилуулсны дараа хийх нислэгийг;

4.1.16.“Улсын нисэхийн багц дүрэм” гэж энэ хуульд нийцүүлэн гаргасан улсын нисэхийн үйл ажиллагааг зохицуулах баримт бичгийг;

4.2.Нисэхийн үйл ажиллагаатай холбоотой энэ хуулиар зохицуулаагүй бусад нэр томъёог Иргэний нисэхийн тухай хуулийн 5 дугаар зүйлд зааснаар хэрэглэнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ УЛСЫН НИСЭХИЙН ТАЛААРХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ

5 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх

5.1. Улсын Их Хурал улсын нисэхийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.1.1. улсын нисэхийг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох;

5.1.2. улсын нисэхийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох.

6 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх

6.1. Засгийн газар нь улсын нисэхийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1. улсын нисэхийг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого, улсын нисэхийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;

6.1.2. улсын нисэхийн эрэн хайх, аврах ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээг чиглүүлэх;

6.1.3. улсын нисэхийн аэродром байгуулах, өөрчлөх, шилжүүлэх, татан буулгах;

6.1.4. улсын нисэхийг хөгжүүлэх төсөл, хөтөлбөрийг батлах;

6.1.5. улсын нисэхийн нисгэгч, инженер техникчид болон нисэхийн тусгай мэргэжлийн жагсаалт, тэдний хөдөлмөрийн хөлсний ерөнхий үнэлгээ, тусгай нэмэгдлийг тогтоох.

7 дугаар зүйл. Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх

7.1. Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1. улсын нисэхийн багц дүрмийг батлах;

7.1.2. улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ерөнхий шинжээч (байцаагч)-ийг томилж;

7.1.3. Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын улсын нисэхийн байцаагч нисгэгч, инженерт хяналт шалгалт явуулах эрх олгох;

7.1.4. энэ хуулийн 15.2, 17.2-т заасан журмыг иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөж батлах;

7.1.5. "улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагын нисгэгч, нисэхийн тусгай мэргэжлийн бүрэлдэхүүний нислэгийн цагийн хөлсний үнэлгээний тусгай норм, зэрэг, зэрэглэлийг тогтоох.

8 дугаар зүйл. Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг

8.1. Улсын нисэхийн үйл ажиллагаа батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хяналтад байна.

8.2. Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

8.2.1. улсын нисэхийн талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах;

8.2.2. улсын нисэхийн хяналт зохицуулалтыг тасралтгүй, үр дүнтэй хэрэгжүүлэхэд нисэхийн мэргэжлээр бэлтгэгдсэн хүний нөөцийн чадавхыг бүрдүүлэх;

8.2.3. улсын нисэхийн аюулгүй байдал, аюулгүй хамгаалалттай холбоотой мэдээллийн санг хөтлөх, холбогдох байгууллагуудтай мэдээлэл солилцох;

8.2.4. улсын агаарын хөлөг, түүний бүрдэл хэсгийн гэрчилгээ, нисэхийн мэргэжлийн үнэмлэх, гэрчилгээ, зэрэг, зэрэглэл олгох, түдгэлзүүлэх, цуцлах;

8.2.5. улсын нисэхийн багц дүрэм болон бусад холбогдох эрх зүйн актыг боловсруулах, батлуулах, бүртгүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;

8.2.6. нислэгт тэнцэх чадварын гэрчилгээний хугацаа дууссан, нислэгт тэнцэх чадвараа алдсан агаарын хөлгийн нислэгийг зогсоох, зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох;

8.2.7. улсын нисэхийн аюулгүй байдал, аюулгүй хамгаалалттай холбоотой хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх;

8.2.8. нислэгийн аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй Улсын нисэхийн багц дүрмээр зохицуулагдаагүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд тодорхой хугацаатай шийдвэр гаргах, холбогдох этгээдэд мэдээлэх;

9 дүгээр зүйл. Цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллагын чиг үүрэг

9.1. Цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллага нь улсын нисэхийн талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

9.1.1. хилийн агаарын бүсэд нислэг үйлдэх зөвшөөрөлд хяналт тавих;

9.1.2. онцгой үүргийн нислэгийн зөвшөөрөл олгох;

9.1.3. байлдааны үүргийн, сургууль-байлдааны үүргийн нислэгийг төлөвлөж, гүйцэтгэх;

9.1.4. улсын агаарын хөлгийн нислэгийн хөдөлгөөнд хяналт тавих;

9.1.5. Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хуулийн 7.1-т заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

9.1.6. Зөвшөөрлийн тухай хуулийн 10.14-т заасан зөвшөөрлийг олгох.

10 дугаар зүйл. Улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагын чиг үүрэг

10.1. Улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллага нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

10.1.1. улсын агаарын хөлөг эзэмшигч байгууллага нь нислэгийн үйл ажиллагаа, нислэгийн аюулгүй байдлыг хангуулах чиг үүрэг бүхий нэгжтэй байх бөгөөд шалгагч зэрэглэлтэй нисгэгч, инженерийг Батлан хамгаалах асуудал эрхэсэн төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлтийг үндэслэн томилох;

10.1.2. энэ хууль, түүнтэй нийцүүлж баталсан эрх зүйн акт, эзэмшиж буй агаарын хөлгийн үйлдвэрлэгчээс гаргасан дүрэм, зааврын хүрээнд нислэгийн үйл ажиллагааг гүйцэтгэх;

10.1.3. нислэгийн аюулгүй байдлыг хангуулах чиглэлээр бүх төрлийн арга хэмжээг зохион байгуулах;

10.1.4. нисэхийн үйл ажиллагааг тасралтгүй хэрэгжүүлэх мэргэжлийн бүрэлдэхүүнийг сургах, хүний нөөцийг бүрдүүлэх;

10.1.5. улсын агаарын хөлөг, түүний нисэх багийн амь нас, эрүүл мэндийг заавал даатгуулсан байх.

10.2. Улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллага нь нисэх онгоц, нисдэг тэрэгний дадлагажууртай байж болно.

10.3. Улсын нисэхийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах үүднээс улсын агаарын хөлгийг ашиглах гарын авлага, техник, технологийн болон бусад холбогдох баримт бичгийг тухайн үйлдвэрлэгч орны хэл дээр ашиглаж болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ УЛСЫН НИСЭХИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИЦУУЛАЛТ

11 дүгээр зүйл. Улсын нисэхийн багц дүрэм

11.1. Улсын нисэхийн багц дүрмээр дараах харилцааг зохицуулна:

11.1.1. улсын агаарын хөлгийг бүртгэх, бүртгэлийн гэрчилгээ, нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгох, сунгах, түдгэлзүүлэх, цуцлах;

11.1.2. нисэхийн мэргэжлийн үнэмлэх, зэрэг, зэрэглэл, эрүүл мэндийн гэрчилгээ олгох, сунгах, түдгэлзүүлэх, цуцлах;

11.1.3. улсын агаарын хөлгөөр нислэг үйлдэх;

11.1.4. нисэхийн инженерийн албыг зохион байгуулах;

11.1.5.улсын нисэхийн аэродромын бүртгэл, ашиглалт, хангалтыг зохион байгуулах;

11.1.6.улсын агаарын хөлгийн нислэгийн үйл ажиллагаа, аюулгүй байдалд хяналт тавих;

11.1.7.улсын агаарын хөлгийн нислэгийн хөдөлгөөний үйл ажиллагааг зохицуулах;

11.1.8.эрэн хайх, аврах ажиллагааг гүйцэтгэх;

11.1.9.улсын нисэхийн агаарын хөлгийн нислэг-техникийн осол зөрчлийг шинжлэн шалгах;

11.1.10.нислэгийн дадлагажуурын цогцолборыг ашиглах;

11.1.11.Цэргийн зориулалттай нисгэгчгүй нисэх хэрэгслийг бүртгэх, гэрчилгээжүүлэх, ашиглах, хяналт тавих.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

УЛСЫН АГААРЫН ХӨЛӨГ, ТҮҮНД ХАМААРАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

12 дугаар зүйл.Улсын агаарын хөлгийн бүртгэл, нислэгт тэнцэх чадвар

12.1.Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Монгол Улсад бүртгэх улсын агаарын хөлөг, түүний бүрдэл хэсгийн бүртгэлийг хөтөлнө.

12.2.Улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллага өөрийн өмчлөл, эсхүл эзэмшилд байгаа бусад улсад бүртгэлгүй агаарын хөлгийг Улсын нисэхийн багц дүрмийн дагуу улсын агаарын хөлгийн бүртгэлд бүртгүүлнэ.

12.3.Энэ хуулийн 12.2-т заасны дагуу бүртгүүлээгүй агаарын хөлгөөр нислэг үйлдэхийг хориглоно.

12.4.Энэ хуулийн 7.1.3-т заасан улсын нисэхийн байцаагч нисгэгч, инженерийн үзлэг, шалгалтаар нислэгийн аюулгүй байдлыг хангасан агаарын хөлөгт нислэгт тэнцэх чадварын гэрчилгээг батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.

12.5.Нислэгт тэнцэх чадварын гэрчилгээнд түүний хүчинтэй хугацаа, агаарын хөлгийн зориулалт, нислэгийн аюулгүй байдлыг хангахад шаардлагатай ангилал, хязгаарлалт болон бусад мэдээллийг тусгана.

12.6.Улсын агаарын хөлгийг бүртгэх, бүртгэлээс хасах, нислэгт тэнцэх чадварыг тодорхойлох, гэрчилгээ олгох, сунгах, цуцлах үйл ажиллагааг Улсын нисэхийн багц дүрмээр зохицуулна.

12.7.Энэ хууль болон Улсын нисэхийн багц дүрмийг зөрчсөн тохиолдолд агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээг түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгоно.

13 дугаар зүйл. Улсын агаарын хөлгийн дарга, нисэх баг

13.1. Улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллага нь нислэгийн аюулгүй байдлыг хангах зорилгоор тухайн төрлийн нислэгийн үйл ажиллагааг гүйцэтгэх шаардлага хангасан нисгэгчийг агаарын хөлгийн даргаар томилно.

13.2. Агаарын хөлгийн дарга, нисэх багийн гишүүд нь батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон хүчин төгөлдөр мэргэжлийн үнэмлэх, гэрчилгээтэй байна. Мэргэжлийн үнэмлэх, гэрчилгээг жил бүр сунгаж баталгаажуулсан байна.

13.3. Агаарын хөлгийн дарга нь нислэгийн аюулгүй байдалд илт аюул тулгарсан, аюул тулгарах нь тодорхой болсон тохиолдолд Улсын агаарын хөлөг болон түүний бүхээгт байгаа хүмүүсийн амь насыг аврах зорилгоор нислэгийн төлөвлөгөө болон нислэгийн хөдөлгөөний удирдагч /удирдлага/-ийн өгснөөс өөр шийдвэр гаргаж болно.

13.4. Агаарын хөлгийн дарга нь энэ хуулийн 14.1.1-т зааснаас бусад нислэгийг гүйцэтгэх үед Иргэний нисэхийн тухай хуулийн 21.3-т заасан эрхийг хэрэгжүүлнэ.

13.5. Байлдааны агаарын хөлгийн нисэх багийн гишүүд нь байлдааны үүргийн нислэг үйлдэх үед үнэмлэхийг улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагын нууцын асуудал хариуцсан албан тушаалтанд хадгалуулна.

13.6. Улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагад олон улсын болон Монгол Улсын иргэний нисэхийн байгууллагаар гэрчилгээжсэн, Улсын нисэхийн багц дүрмийн шаардлагыг хангасан Монгол Улсын болон гадаад улсын иргэн гэрээгээр үүрэг гүйцэтгэж болно.

13.7. Гэрээгээр ажиллах иргэн нь батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас улсын агаарын хөлгөөр нисэх, техник үйлчилгээ хийх эрхийг авсан байна.

14 дүгээр зүйл. Улсын агаарын хөлгийн нислэгийн ангилал

14.1. Улсын агаарын хөлгийн нислэг дараах ангилалтай байна:

- 14.1.1. байлдааны үүргийн нислэг;
- 14.1.2. онцгой үүргийн нислэг;
- 14.1.3. тусгай үүргийн нислэг;
- 14.1.4. захиалгат нислэг;
- 14.1.5. сургууль-байлдааны нислэг;
- 14.1.6. шалгалт, туршилтын нислэг;
- 14.1.7. сургууль-дадлагын нислэг;
- 14.1.8. олон улсын нислэг.

14.2. Энэ хуулийн 14.1.1, 14.1.5-д заасан нислэгийг цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллагын баталсан дүрмээр зохицуулна.

14.3. Улсын агаарын хөлгөөр захиалгат нислэг үйлдэх бол Иргэний нисэхийн тухай хууль, дүрмийн холбогдох зохицуулалтыг баримтална.

14.4.Улсын агаарын хөлгийг агаарт болон газарт шалгах, засвар, техникийн үйлчилгээ, тоног төхөөрөмж суурилуулсны дараа шалгалт, туршилтын нислэг үйлдэнэ.

14.5.Энэ зүйлийн 14.1.2, 14.1.3, 14.1.4-т заасан нислэг, түүнтэй холбогдон гарах зардлыг тухайн захиалагч тал хариуцна.

15 дугаар зүйл. Улсын агаарын хөлгийн нислэгийн хөдөлгөөний зохицуулалт

15.1.Улсын агаарын хөлгийн байлдааны үүргийн нислэгийн хөдөлгөөний зохицуулалтыг цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллагын шийдвэрээр Агаарын цэргийн командлал хэрэгжүүлнэ.

15.2.Улсын агаарын хөлгийн онцгой болон тусгай үүргийн нислэгийн хөдөлгөөний зохицуулалтыг батлан хамгаалах болон иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хамтарсан журмаар зохицуулна.

15.3.Энэ хуулийн 14.1.4, 14.1.5, 14.1.6, 14.1.7, 14.1.8-д заасан нислэгийн хөдөлгөөнийг Улсын нисэхийн багц дүрмээр зохицуулна.

ТАВДУГААР БҮЛЭГ УЛСЫН НИСЭХИЙН АЭРОДРОМЫН АШИГЛАЛТ

16 дугаар зүйл.Улсын нисэхийн аэродром

16.1.Улсын нисэхийн аэродромыг улсын бүртгэлд бүртгэх, бүртгэлээс хасах, гэрчилгээ олгох, цуцлах, аэродром ашиглах үйл ажиллагаа, түүнд тавигдах шаардлагыг Улсын нисэхийн багц дүрмээр зохицуулна.

16.2.Цэргийн зориулалттай нисэхийн аэродром байгуулах, өөрчлөх, шилжүүлэх, татан буулгах, түүний бэлэн байдал, түүнд тавигдах шаардлагыг тогтоох асуудлыг цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллагын санал болгосноор Зэвсэгт хүчний ерөнхий командлагчтай зөвшилцөн Засгийн газар шийдвэрлэнэ.

16.3. Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь улсын нисэхийн аэродром байгуулах, түүний бэлэн байдал, түүнд тавигдах шаардлагыг тогтоох тухай саналыг боловсруулж Засгийн газраар шийдвэрлүүлнэ.

16.4.Улсын нисэхийн зориулалттай аэродром нь батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гэрчилгээжсэн байна.

16.5.Улсын нисэхийн аэродромын бүртгэлийг батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрхэлнэ.

16.6.Улсын нисэхийн аэродромын аюулгүйн бүсийн орчимд үйлдвэрлэл, үйлчилгээ, барилга байгууламж барихыг хориглоно.

16.7.Улсын нисэхийн аэродромын аюулгүй байдал, ашиглалт, хамгаалалт, бэлэн байдал, аэродромыг техник, технологийн баримт бичигт зааснаар тоноглож, ашиглахыг улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллага хариуцна.

17 дугаар зүйл.Аэродромыг хамтран ашиглах

17.1.Улсын болон иргэний нисэхийн зориулалтаар хамтран ашиглах аэродром нь иргэний нисэхийн аэродромд тавигддаг шаардлагыг хангасан байна.

17.2.Улсын болон иргэний нисэхийн аэродромыг хамтран ашиглах харилцааг батлан хамгаалах болон иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтарсан журмаар зохицуулна.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ НИСЛЭГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, АЮУЛГҮЙН ХАМГААЛАЛТ

18 дугаар зүйл.Улсын нисэхийн аюулгүй байдлын хяналт

18.1.Улсын нисэхийн аюулгүй байдлын хяналт нь улсын агаарын хөлгийн нислэгийн аюулгүй байдлын болон нислэгийн үйл ажиллагааны хяналтаас бүрдэнэ.

18.2.Улсын нисэхийн аюулгүй байдлын хяналтыг энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан байгууллага хэрэгжүүлнэ.

18.3.Улсын нисэхийн үйл ажиллагааг хариуцсан бүтцийн нэгжийн улсын хяналтын байцаагч нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

18.3.1.эрх бүхий албан тушаалтнаас олгосон албаны болон хувийн дугаар бүхий үнэмлэх, тэмдэг, түүнчлэн албан шаардлага, зөвлөмж, дүгнэлт, акт бүхий хэвлэмэл хуудас хэрэглэх;

18.3.2.хяналт шалгалт хийх зорилгоор улсын нисэхийн үйл ажиллагаатай холбогдолтой объект, барилга байгууламжид саадгүй нэвтрэх;

18.3.3.улсын нисэхийн үйл ажиллагаатай холбоотой баримт бичгийн хувийг шаардан гаргуулах;

18.3.4.шаардлагатай тохиолдолд улсын агаарын хөлгийг саатуулах;

18.3.5.холбогдох этгээдийн улсын нисэхийн баримт бичгийг түр хураах.

18.3.6.дээрх заалтын дагуу хийгдэх үйлдэл, байцаагчийн үүрэг даалгаврыг гүйцэтгэх хугацаа болон бусад нэмэлт зохицуулалтыг Улсын нисэхийн багц дүрмээр нарийвчлан зохицуулна

19 дүгээр зүйл.Улсын нисэхийн аюулгүйн хамгаалалт

19.1.Хуульд өөрөөр заагаагүй бол улсын нисэхийн аюулгүйн хамгаалалтыг хангах зорилгоор зорчигчдын бие болон гар тээш, ачаанд агаарын хөлгийг эзэмшигч болон холбогдох мэргэжлийн байгууллага зохих зааврын дагуу үзлэг хийнэ.

19.2.Энэ хуулийн 19.1-т заасан үзлэгээс татгалзсан зорчигч тээвэрлэхийг хориглох ба шаардлагатай гэж үзвэл эрх бүхий байгууллагад шилжүүлнэ.

19.3.Улсын агаарын хөлгөөр онцгой үүргийн нислэг үйлдэх үед аюулгүйн хамгаалалтыг хангах зорилгоор нисэх багийн бүрэлдэхүүнд хамгаалалтын ажилтныг ажиллуулж болно.

ДОЛДУГААР БҮЛЭГ УЛСЫН АГААРЫН ХӨЛГИЙГ ЭРЭН ХАЙХ, АВРАХ АЖИЛЛАГАА

20 дугаар зүйл.Эрэн хайх, аврах ажиллагаа

20.1.Аюул тулгарсан болон аюулд нэрвэгдсэн улсын агаарын хөлөг, түүний нисэх баг, зорчигчдыг эрэн хайх, аврах, тусламж үзүүлэх, тэдгээрийг ослын газраас шилжүүлэн зөөвөрлөх ажиллагааг батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын удирдлага дор тухайн агаарын хөлөг эзэмшигч байгууллагатай хамтран, тусгайлан бэлтгэгдсэн бие бүрэлдэхүүн, техник хэрэгсэл ашиглан гүйцэтгэнэ.

20.2.Эрэн хайх, аврах ажиллагааг улсын болон иргэний нисэхийн байгууллагууд, холбогдох бусад байгууллага хамтран гүйцэтгэж болно.

20.3.Орон нутгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, аж ахуйн нэгж, иргэд аюулд нэрвэгдсэн улсын агаарын хөлгийн талаар өөрт мэдэгдсэн мэдээллийг зохих байгууллагад нэн даруй мэдэгдэх, нисэх баг, зорчигчдын амь насыг аврах, тэдэнд эмнэлгийн болон бусад зайлшгүй тусламж үзүүлэх, түүнчлэн агаарын хөлөг, түүний баримт бичгийг хамгаалалтад авах үүрэг хүлээнэ.

20.4.Энэ хуулийн 20.1-т заасан ажиллагааг Улсын нисэхийн багц дүрмээр зохицуулна.

21 дүгээр зүйл.Аюулд нэрвэгдсэн агаарын хөлөг, нисэх баг, зорчигчдыг эрэн хайх, аврах ажиллагааг зогсоох

21.1.Аюулд нэрвэгдсэн улсын агаарын хөлөг, нисэх баг, зорчигчдыг эрэн хайх бүх арга хэмжээ үр дүнгүй болсон тохиолдолд эрлийн ажлыг зогсоох шийдвэрийг уг агаарын хөлгийг эзэмшигч байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар гаргана.

НАЙМДУГААР БҮЛЭГ УЛСЫН НИСЭХИЙН НИСЛЭГ-ТЕХНИКИЙН ОСОЛ ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ

22 дугаар зүйл.Улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаа

22.1.Улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааг агаарын хөлгийн осол, зөрчлийн нөхцөл, шалтгааныг тогтоох зорилгоор хэрэгжүүлнэ.

22.2.Энэ хуулийн 7.1.2-т заасны дагуу томилогдсон ерөнхий шинжээч нь нисгэгч, инженер, эсхүл шинжлэн шалгах чиглэлээр мэргэшсэн нисэхийн бусад мэргэжилтэй, хараат бус, бие даасан байна.

22.3.Улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллага болон холбогдох бусад этгээд осол, зөрчилд өртсөн агаарын хөлөгтэй холбоотой эд мөрийн баримтыг шинжлэн шалгах ажиллагааг гүйцэтгэж дуусах хүртэл хадгалж, хамгаална.

23 дугаар зүйл.Улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шалгах ерөнхий шинжээчийн бүрэн эрх, чиг үүрэг

23.1.Улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шалгах ерөнхий шинжээч нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

23.1.1.албан үүргээ гүйцэтгэхдээ улсын нисэхийн үйл ажиллагаатай холбоотой газруудад саадгүй нэвтрэх;

23.1.2.шинжлэн шалгах ажиллагаанд шаардлагатай мэдээ, судалгаа, тодорхойлолт болон бусад нотлох баримтыг холбогдох хүн, хуулийн этгээдээс шаардан авах;

23.1.3.Улсын нисэхийн багц дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргах;

23.1.4.улсын агаарын хөлгийн эзэмшигч байгууллагын нислэгийн бэлтгэл, гүйцэтгэлд үнэлэлт өгөх;

23.1.5.улсын нисэхийн техникийн ашиглалтын горимд хяналт тавьж дүгнэлт гаргах, зөвлөмж өгөх;

23.1.6.улсын агаарын хөлгийн нислэг-техникийн осол, зөрчлийн шалтгааныг үнэн зөв тогтоох, шаардлагатай мэдээ, судалгаа, бусад баримт бичгийг холбогдох этгээдээс шаардан гаргуулж авах.

23.2.Улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шалгах ерөнхий шинжээч нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

23.2.1.улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааг зохион байгуулах;

23.2.2.улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах, ангилах, бүртгэх ажиллагааг гүйцэтгэх;

23.2.3.улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах комиссын дүрмийг батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр батлуулах;

23.2.4.улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах комисс томилуулах тухай саналаа батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулж, шийдвэрлүүлэх;

23.2.5.улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчилтэй холбоотой мэдээллийг цуглуулан дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөл, нөлөөлсөн хүчин зүйлсийн талаар тайлан гаргах.

24 дүгээр зүйл.Улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах комисс, түүний бүрэн эрх

24.1.Улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах комисс, түүний бүрэн эрх:

24.1.1.улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчил болсон газарт саадгүй нэвтрэх, шинжлэн шалгах ажиллагаанд хамааралтай ослын үлдэгдэл, эд зүйлст хяналтаа тогтоох;

24.1.2.шинжлэн шалгах ажиллагааны явцад эд мөрийн баримт хамгаалах, агаарын хөлөг, түүний үлдэгдэл байгаа бүсэд зөвшөөрөлгүй этгээд нэвтрэх, эд зүйлс үрэгдэж гэмтэх, алдагдахаас хамгаалах боломжит бүх арга хэмжээг авах;

24.1.3.ослын газрыг хамгаалалтад авах асуудлыг эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлэх;

24.1.4.шинжлэн шалгах ажиллагааг гүйцэтгэхэд шаардлагатай ажиглагч, оролцогчийг томилох;

24.1.5.ослын газрын хамгаалалт буулгах, цаашид шинжлэн шалгах ажиллагаанд шаардлагагүй болсон агаарын хөлөг, түүний бүрдэл хэсэг, эд зүйлсийг хадгалалтаас чөлөөлөх;

24.1.6.шинжлэн шалгах ажиллагааны тайлан гаргах.

24.2.Улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийн шалтгааныг тогтоох, шинжлэн шалгах ажиллагаанд шаардлагатай гэж үзвэл дотоод, гадаадын мэргэжилтэн /байгууллага/-ийг оролцуулж болно.

24.3.Улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах комисс нь гарсан осол, зөрчлийн нөхцөл, шалтгааныг тогтоож, цаашид уг осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

25 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

25.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хууль болон Цэргийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

25.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

Гарын үсэг

Багхансан эрх?

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20... оны ... дугаар
Сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

УЛСЫН НИСЭХИЙН ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2003 оны 05 дугаар сарын 30-ны өдөр батлагдсан Улсын нисэхийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Улсын нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20... оны ... дугаар
Сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Зэвсэгт хүчний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.23 дахь заалтын "... 6.2.3-т ..." гэснийг "... 9.1.1, 9.1.2-т ..." гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Улсын нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

УЛСЫН НИСЭХИЙН ТУХАЙ ХУУЛЬ
/ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ
УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2025 ОН

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Улсын Их Хурлын 2003 оны нэгдсэн чуулганаар Улсын нисэхийн тухай хуулийг хэлэлцэн баталж, нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, бусад хууль тогтоомжид нийцүүлэх шаардлагын үүднээс нийт 6 удаа холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

Улсын нисэхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах үнэлгээний тайланг хийхдээ холбогдох хууль тогтоомжийг судлан үзсэний үндсэн дээр дараах хууль зүйн үндэслэлийн хүрээнд боловсруулах нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

-Монгол Улсын Үндсэн хуулийн Арван нэгдүгээр зүйлийн 1-д “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн” гэж, мөн зүйлийн 2-т “Монгол Улс өөрийгөө хамгаалах зэвсэгт хүчинтэй байна. Зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалт, түүнд алба хаах журмыг хуулиар тогтооно.” гэж, Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 6 дахь заалтад “улсыг батлан хамгаалах хүчин чадлыг бэхжүүлж, үндэсний аюулгүй байдлыг хангах” гэж;

-Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Тавдугаар зүйлийн Зорилт 5.2-т “Төрийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тодорхойлох замаар чиг үүрэг, эрх мэдлийн хуваарилалтыг нарийвчилна” гэж;

-Монгол Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичгийн 6.2-т “Монгол Улсын батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны харилцааг зохицуулах хууль, эрх зүйн хэм хэмжээний цогц байдлыг хангана” гэж;

-Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 4.1.2-т “Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж, ажил үүргийн давхцал, хийдлийг арилгаж, харилцан зохицуулалт хийх механизмыг боловсронгуй болгоно” гэж;

-Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1-д “батлан хамгаалах бодлого, тогтолцооны эрх зүйн үндсийг тогтоох” гэж Улсын Их Хурлын бүрэн эрхэд;

-Зэвсэгт хүчний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 12.1.2-т “зэвсэгт хүчний чадавхыг нэмэгдүүлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх” гэж Засгийн газрын бүрэн эрхэд тус тус заажээ.

Мөн Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 4.1.3-т “Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж, ажил үүргийн давхцал, хийдлийг арилгаж, харилцан зохицуулалт хийх механизмыг боловсронгуй болгоно” гэж заасан нь тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль зүйн шаардлага гэж үзэж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 41 дүгээр “Батлан хамгаалах яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар шинэчлэн батлах тухай” тогтоолын 1.8 дахь хэсэгт “Батлан хамгаалах яамны

зохион байгуулалтын бүтцэд “Улсын нисэхийн хэлтэс”-тэй байхаар шинээр тусгасан нь цаг үеэ олсон, улсын нисэхийн тухай хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд улсын агаарын хөлөгтэй болж, тэдгээрийн мэргэжил арга зүйн удирдамжаар хангах тухайн нэгжийн гүйцэтгэх чиг үүргийг хуульд нарийвчлан тусгаж, цаашид хэрэгжүүлэх шаардлагатай, тулгамдсан асуудлуудыг зохицуулах бодлогын зохицуулалтуудыг тус хуульд тусгах бас нэг хэрэгцээ, шаардлага нь юм.

Нөгөөтээгүүр улсын нисэхийн аюулгүй ажиллагааг хангах, хуульд заасан нислэг-техникийн осол, зөрчлийг шалгах ерөнхий шинжээчийг томилох, албан тушаалын харьяаллыг тодорхой болгох, нисэхийн үйл ажиллагаа Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нэгжийн бүрэн эрхэд Улсын нисэхтэй холбоотой эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгож баримтлах үндэслэлийг тусгаж өөрчлөхөөс гадна Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 486 дугаар тогтоолоор улсын нисэхтэй холбоотой хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтийг боловсронгуй болгох, улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагуудыг бодлогын нэгдсэн удирдлагаар хангах, нисэхийн аюулгүй байдалд хяналт тавих, зохицуулалтын тогтолцоог сайжруулах зэрэг асуудлуудыг тусгах зэрэг зүй ёсны шаардлага байгаа болно.

Мөн нисэхийн салбарт төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагын тоо, гүйцэтгэх үүргийн цар хүрээ, оролцоо өргөжиж байгаа болон Улсын нисэхийн асуудал хариуцсан бүтцийн нэгж Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад байгуулагдсантай холбогдуулан Улсын нисэхийн хууль тогтоомж, бодлогын хэрэгжилттэй холбоотой асуудал, хүндрэл бэрхшээлийг арилгах, улсын агаарын хөлгөөр нислэг үйлдэх, улсын нисэхийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлыг хангах, улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагын албан хаагчид тавих мэргэжлийн чадвар, шаардлага, хариуцлагыг өндөржүүлэх, эрх зүйн орчинг сайжруулах зорилгоор Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хууль, Иргэний нисэхийн тухай шинэчилсэн найруулгын тухай хуультай уялдуулах ч асуудал байгаа юм.

Практик шаардлагын хувьд Улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагын (Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлал, Онцгой байдлын Ерөнхий газар, Хил хамгаалах Ерөнхий газар) нислэгийн үйл ажиллагааг Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын Улсын нисэхийн хэлтэс “Улсын нисэхийн тухай хууль”, “Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хууль” бусад холбогдох дүрэм, журам, зааврын хүрээнд улсын агаарын хөлгийн бүртгэл, нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгох, цуцлах, сунгах болон нисэх, инженер техникчдийн бүрэлдэхүүнд нисэхийн мэргэжлийн үнэмлэх, зэрэглэл, зэрэг олгох, сунгах, батламжлах үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа бөгөөд яаманд шинээр байгуулагдсан Улсын нисэхийн хэлтэс нь дээр дурдсан үүрэг, чиглэл, яам, агентлаг хоорондын нислэгтэй холбоотой харилцаа, нислэгийн аюулгүй ажиллагааг нэгдсэн удирдлагаар ханган ажиллах хууль эрх зүйн орчин зайлшгүй шаардлагатай байна.

2018 тус хуульд орсон нэмэлт, өөрчлөлтөөр Засгийн газрын гишүүний бүрэн эрх, улсын нисэхийн багц дүрэм, байлдааны агаарын хөлгийн нисэх бүрэлдэхүүнд мэргэжлийн үнэмлэх олгохгүй, улсын агаарын хөлгийн ангилал, нислэг-техникийн осол зөрчлийн шинжлэн шалгах зохицуулалтыг өөрчилсөн боловч байлдааны агаарын хөлгийн нислэг, нисэх, инженер, техникчдийн бүрэлдэхүүн, улсын агаарын хөлгийн нислэгийн ангилал, нислэг үйлдэх, нисэх, инженер техникчдийн бүрэлдэхүүнийг батламжлах, бүртгэх, гэрчилгээжүүлэх, нисэхийн аюулгүй байдлын хяналт, дүрэм, журам, зааврыг уялдуулан зохицуулах, агаарын хөлгийг даатгалын

асуудалд хуулиар зохицуулалт нь орхигдсон зэрэг байдлаас дор дурдсан бэрхшээл, хүндрэлийг арилгаж, хуулийн хийдэл, гажуудлыг засах шаардлагатай байна. Үүнд:

-Улсын нисэхийн талаар хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын бүрэн эрх тодорхойлох

-Улсын нисэхийн салбарын хөгжлийг төрөөс дэмжих, гүйцэтгэх үүрэг, чадавхыг өргөжүүлэх асуудлыг зохицуулах;

-Улсын агаарын хөлгөөр нислэг үйлдэх, улсын нисэхийн орчинд үйл ажиллагаа явуулах гадаадын иргэн болон иргэний нисэхийн нисгэгч, инженер техникийн мэргэжлийн бүрэлдэхүүний зохицуулалтыг тусгах;

-Улсын нисэхийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан нислэгийн ангилалд улсын агаарын хөлгийн зарим байгууллагуудын үйл ажиллагаанд зохицоогүй, шаардлагатай хэмжээнд зохицуулагдаагүй байгааг тусгах;

-Улсын нисэхийн тухай хууль, улсын нисэхийн багц дүрмээс бусад дүрэм, журмуудыг улсын нисэхийн багц дүрмийн хүрээнд багцлах;

-Улсын нисэхийн асуудал хариуцсан бүтцийн нэгж Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бий болсонтой холбогдуулан Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрх, үүрэгт холбогдох эрх зүйн зохицуулалт бий болгож, хуулийн нийцлийг хангах;

-Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, тогтоомж, дүрмийн хүрээнд агаарын хөлгийн бүртгэл, гэрчилгээ, нисэхийн мэргэжлийн үнэмлэх, зэрэг, зэрэглэл олгох, батламжлах асуудлыг эрх зүйн хувьд тодорхой болгох шаардлага байна.

Шинэчилсэн найруулгын төслөөр цэргийн мэргэжлийн удирдлагын дээд байгууллагын чиг үүрэг болон улсын агаарын хөлгийн бүртгэл, улсын агаарын хөлгийн дарга, нисэх баг, агаарын хөлгийн даатгалжуулалт, нислэгийн ангилал, эрэн хайх, авран туслах үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтуудад нэмэлтээр шинэ зохицуулалтыг, хуулийн хэд хэдэн зүйлийн хэсэг, заалтад өөрчлөн найруулга хийх замаар боловсронгуй болгоно.

Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулснаар хуульд заасан эрх зүйн зохицуулалтууд боловсронгуй болох, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, холбогдох хууль тогтоомжтой нийцүүлэх замаар хууль тогтоомжийг нэг мөр ойлгож хэрэглэх боломж нэмэгдэх зэрэг олон давуу тал бий болох юм.

Иймд дээр дурдсан тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийн тулд Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5.1-д заасны дагуу Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах нь оновчтой гэж үзсэн болно.

УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйлд “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах” гэж, 12 дугаар зүйлийн 12.1.2-т “хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалыг Засгийн газар баталж мөрдүүлнэ.” гэж тус тус заасны хүрээнд Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ,

шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын /цаашид Аргачлал гэх/ 2.1-д заасан үе шатны дагуу хийж гүйцэтгэлээ.

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

Улсын Их Хурлын 2003 оны нэгдсэн чуулганаар Улсын нисэхийн тухай хуулийг хэлэлцэн баталж, эдүгээ 22 жилийн хугацаанд тус хуульд холбогдох өөрчлөлтүүдийг оруулсан хэдий ч нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, нисэхийн үйл ажиллагааны хөгжил дэвшил, шинээр батлагдсан холбогдох бусад хууль тогтоомжтой нийцүүлэх зэрэг асуудлыг цэгцэлж, боловсронгуй болгох зайлшгүй хэрэгцээ шаардлага байна гэж үзлээ.

Улсын нисэхийн салбарт төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагын тоо, гүйцэтгэх үүргийн цар хүрээ, оролцоо өргөжиж байгаа болон Улсын нисэхийн асуудал хариуцсан бүтцийн нэгж Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад байгуулагдсантай холбогдуулан Улсын нисэхийн хууль тогтоомж, бодлогын хэрэгжилттэй холбоотой асуудал, хүндрэл бэрхшээлийг арилгах, улсын агаарын хөлгөөр нислэг үйлдэх, улсын нисэхийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлыг хангах, улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагын албан хаагчид тавих мэргэжлийн чадвар, шаардлага, хариуцлагыг өндөржүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах ажил чухлаар тавигдаж байна.

Мөн хуулийн төслөөр эрх зүйн харилцааг сайжруулахтай холбогдсон асуудлаар хүн, хуулийн этгээдээс Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу саналыг авч, байгууллагын цахим хаягт байрлуулж саналыг авна.

Иймд Аргачлалын 3-т заасны дагуу асуудалд дүн шинжилгээ хийхдээ асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх гэж байгаа асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоож, тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг оновчтой тогтоож, улмаар түүнийг үүсгэж байгаа шалтгаан, нөхцөлийг тодорхойлохоор зорилоо.

1.1. Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал:

Улсын нисэхийн үйл ажиллагаатай холбоотой эрх бүхий байгууллага, албан тушаалтны эрх, үүрэг хэм хэмжээг тодорхойлох, улсын нисэхийн үйл ажиллагаа, зохион байгуулалтыг нэгдсэн удирдлагаар хангах болон улсын агаарын хөлгийн бүртгэл, улсын агаарын хөлгийн дарга, нисэх баг, нислэгийн ангилал, эрэн хайх, авран туслах болон шинээр худалдан авсан хүн тээврийн агаарын хөлгийг даатгалжуулах үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтууд нэмэх, хуулийн зарим зохицуулалтад өөрчлөн найруулга хийх замаар боловсронгуй болгох шаардлага байгаа болно.

- Эрх зүйн зохицуулалт: Монгол Улсын Үндсэн хуулийн Арван нэгдүгээр зүйлийн 1-д “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн” гэж, мөн зүйлийн 2-т “Монгол Улс өөрийгөө хамгаалах зэвсэгт хүчинтэй байна. Зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалт, түүнд алба хаах журмыг хуулиар тогтооно.” гэж, Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 6 дахь заалтад “улсыг батлан хамгаалах хүчин чадлыг бэхжүүлж, үндэсний аюулгүй байдлыг хангах” гэж Засгийн газрын үндсэн бүрэн эрхэд заажээ.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Тавдугаар зүйлийн Зорилт 5.2-т “Төрийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тодорхойлох замаар чиг үүрэг, эрх мэдлийн хуваарилалтыг нарийвчилна” гэж; Монгол Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичгийн 6.2-т “Монгол Улсын батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны харилцааг зохицуулах хууль, эрх зүйн хэм хэмжээний цогц байдлыг хангана” гэж; Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 4.1.2-т “Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж, ажил үүргийн давхцал, хийдлийг арилгаж, харилцан зохицуулалт хийх механизмыг боловсронгуй болгоно” гэж, Зэвсэгт хүчний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 12.1.2-т “зэвсэгт хүчний чадавхыг нэмэгдүүлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх” гэж Засгийн газрын бүрэн эрхэд тус тус заасан нь хуулийн төслийг боловсруулах эрх зүйн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлогдож байна.

Практик хэрэгжилтийн байдал: Улсын нисэхийн тухай хуультай холбогдуулан хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах дараах практик хэрэгцээ шаардлага байгааг дээр дурдсан болно.

1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээдийг тодорхойлсон байдал:

Дээр дурдсан нөхцөл байдлаас дүгнэж үзвэл холбогдох зохицуулалтыг Улсын нисэхийн тухай хуульд тусгахгүй байх нь Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичигт болон батлан хамгаалахын багц хуулиудад заасан улсын нисэхийн үйл ажиллагаа, нэгдсэн удирдлага, эрх бүхий байгууллага, алба хаагчийн хууль ёсны эрх ашигт сөргөөр нөлөөлж байна гэж үзэх үндэстэй байна.

	Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг	Нөлөөлж буй хэлбэр
1	Улсын нисэхийн тухай хуулийн зохицуулалтад хамаарч байгаа нисэхийн үйл ажиллагаа эрхэлдэг төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, алба хаагч, иргэн хамаарна.	-Тус хуулийн зохицуулалтад хамаарч байгаа байгууллага, алба хаагч, иргэний үйл ажиллагаа, эрх, үүрэгтэй холбогдоно.

1.3. Асуудлыг үүсгэж буй учир шалтгаан:

Холбогдох нөхцөл байдлыг судлан үзвэл дараах учир шалтгаантай байна. Эдгээрийг багцлан үзвэл:

-Улсын нисэхийн талаар хэрэгжүүлэх зарим эрх бүхий байгууллагын бүрэн эрх тодорхойгүй;

-Улсын нисэхийн үйл ажиллагааг төрөөс дэмжих, гүйцэтгэх үүрэг, чадавхыг өргөжүүлэх асуудлыг хуулиар зохицуулсан асуудал хангалтгүй;

-Улсын агаарын хөлгөөр нислэг үйлдэх, улсын нисэхийн орчинд үйл ажиллагаа явуулах гадаадын иргэн болон иргэний нисэхийн нисгэгч, инженер техникийн мэргэжлийн бүрэлдэхүүний талаарх зохицуулалт тодорхой бус;

-Улсын нисэхийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан нислэгийн ангилалд улсын агаарын хөлгийн зарим байгууллагуудын үйл ажиллагаа нь зохицоогүй, шаардлагатай хэмжээнд зохицуулагдаагүй;

-Улсын нисэхийн тухай хууль, улсын нисэхийн багц дүрмээс бусад дүрэм, журмуудыг улсын нисэхийн багц дүрмийн хүрээнд багцлаагүй;

-Шинэ төрлийн хүн тээврийн агаарын хөлгийг даатгалд хамруулахтай холбогдсон зохицуулалт дутмаг;

-Улсын нисэхийн асуудал хариуцсан бүтцийн нэгж Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад байгуулагдсантай холбогдуулан Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрх, үүрэгт зохицуулалт хийх;

-Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, тогтоомж, дүрмийн хүрээнд агаарын хөлгийн бүртгэл, гэрчилгээ, нисэхийн мэргэжлийн үнэмлэх, зэрэг, зэрэглэл олгох, батламжлах асуудлыг тодорхой болгох, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хууль тогтоомжид нийцүүлэх зэрэг болно.

Хуулийг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэх, хуульд нийцүүлэх, шаардлагатай зохицуулалтыг хуульчлах зэрэг асуудлыг тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх юм.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОМЬЁОЛСОН БАЙДАЛ

Эрх зүйн зохицуулалтын хувьд тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж холбогдох эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан тогтоох асуудал тулгамдаж байна.

Иймд Аргачлалын 4-т заасны дагуу асуудлыг шийдвэрлэх зорилтыг дараах байдлаар тодорхойлж байна.

Зорилт: Улсын нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх, эрх бүхий байгууллага, албан тушаалтын эрх, үүргийг тодорхойлох, шаардлагатай эрх зүйн зохицуулалтыг тусгах, эрх зүйн орчинг нь боловсронгуй болгох зэрэг бусад хийдэлтэй, гажуудлыг засах асуудлыг хуулиар цэгцлэх” зэрэг болно.

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЭРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, Аргачлалын 5-д заасны дагуу зорилгод хүрэх байдал буюу тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар зорилтыг хангаж чадах эсэх, зардал, үр өгөөжийн харьцаа буюу хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үзүүлэх сөрөг, эерэг өөрчлөлтийг харьцуулан судалж дараах дүгнэлтийг гаргав.

Хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1. Тэг хувилбар	Шийдвэрлэвэл зохих асуудлыг хэвээр нь үргэлжлүүлбэл тодорхой үр дүнд хүрэх боломжгүй.	Нэмэлт зардал гарахгүй ч, асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөлийг тодорхой хэмжээнд шийдвэрлэнэ.	Үр дүн эерэг

2.	Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх	Хэвлэл, мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан тус хууль тогтоомжийн талаар олон нийтийг соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах нь хууль тогтоомжийн талаар иргэд олон нийтийн ойлголтыг батжуулах хэдий ч асуудлыг шийдвэрлэх боломжгүй.	Хэвлэл, мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан тус хууль тогтоомжийн талаар олон нийтийг соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах, хууль тогтоомжийг иргэдэд сурталчлан таниулахтай холбоотойгоор төсвөөс зардал гаргахгүй ч тодорхой хэмжээнд шийдвэрлэнэ.	Үр дүн эерэг, сөрөг
3	Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх	Тус хуультай хамаарал бүхий асуудлыг зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийснээр үр дүнд хүрэх боломжгүй.	Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийснээр үр дүнд хүрэхгүй.	Үр дүн сөрөг
4	Төрөөс санхүүгийн интервенц хийх	Төрөөс санхүүгийн интервенц хийх нь улсын нисэхийн харилцаанд чухал нөлөө үзүүлэх хэдий ч асуудлыг бүрэн шийдвэрлэхэд үр дүн муутай байна.	Төрөөс санхүүгийн интервенц хийснээр улсын нисэхтэй холбоотой хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх боломжтой хэдий ч эрх зүйн зохицуулалтыг бий болгохгүйгээр зохих үр дүнд хүрэхгүй юм.	Үр дүн сөрөг
5	Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх	Монгол Улсын Үндсэн хуулийн 11 дүгээр зүйлийн 1-д “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн.” гэж заасан ба уг үүргийг төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх боломжгүй юм.	Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн.” гэж заасан ба уг үүргийг төрийн бус байгууллага, хувийн хэвлээр гүйцэтгүүлэх боломжгүй юм.	Үр дүн сөрөг
6	Захиргааны шийдвэр гаргах	Хамрагдах хүрээ, оролцогч талуудын хариуцлагыг нэмэгдүүлэх, хяналт сайжрах боломж нэмэгдэнэ.	Захиргааны акт гаргах замаар улсын нисэхтэй холбоотой харилцааг шийдэх боломж нэмэгдэнэ.	Тодорхой үр дүнд хүрнэ.
7	Тухайн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах	Улсын нисэхийн талаарх зохицуулалт сайжирна.	Тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар тухайн хууль боловсронгуй болох,	Үр дүнтэй

			хуулийг нэг мөр ойлгох, хэрэглэх боломж нэмэгдэнэ.	
--	--	--	--	--

Практик амьдралд тулгарч байгаа зарим асуудлыг хууль тогтоомжид өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх талаар холбогдох дүгнэлтийг хийсэн нь Аргачлалын 5.4-т “Дараах тохиолдолд хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг шууд сонгоно: 5.4.4-т “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу хийсэн үнэлгээнээс тухайн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэсэн зөвлөмж гарсан бол” гэж заасантай нийцэж байх тул хуулийн төсөл боловсруулах хувилбарыг шууд сонгосон болно.

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАНУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Аргачлалын 6-д заасны дагуу хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар нэгтгэн гаргав.

6.1.1. Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөний үнэлгээ.

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ (Хүснэгт 1)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1. Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Үгүй	Ялгаварлан гадуурхсан зохицуулалтыг тусгахгүй.
	1.1.2. Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Ялгаварлан гадуурхсан зохицуулалтыг тусгахгүй.
	1.1.3. Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	Тийм	Үгүй	Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ биш.
	1.2. Оролцоог хангах			
	1.2.1. Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцоо боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	Үгүй	Холбогдох зохицуулалтыг хуульд тусгахдаа эрх, ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа бүлгүүдтэй мэдээлэл

				хуваалцаж, оролцоог хангасан.
	1.2.2.Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Бүлгүүдийг тусгайлан тодорхойлж, тэдэнд үзүүлэх үр нөлөөг тооцсон.
	1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Үгүй	Хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах боломж нэмэгдэнэ.
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Шударга, тэгш эрх, үр өгөөжтэй байх нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд чиглүүлсэн.
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Үгүй	Хариуцлагатай холбоотой зохицуулалт тусгахгүй.
2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх	Тийм	Үгүй	Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгахгүй.
	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	Үгүй	Зарим хориглолт, хязгаарлалтыг хуулиар тогтоохгүй.
3. Эрх агуулагч	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	- Улсын нисэхийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага, албан тушаалтан
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон зохицуулалт байхгүй.
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	Үгүй	Эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзсэн үзсэн зохицуулалт агуулаагүй.

	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх /хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй/	Тийм	Үгүй	Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг агуулаагүй.
4. Үүрэг хүлээгч	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Төрийн байгууллага, иргэн, байгууллага үүрэг хүлээнэ.
5. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1.Жендерийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	Үгүй	Жендерийн үзэл баримтлалтыг зохицуулалт агуулгаагүй.
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Хуульд тусгах зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан нийтлэг зарчмын хүрээнд боловсруулагдана.

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ
(Хүснэгт 2)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэхгүй.
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

чадвар болон тогтвортой байдал	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөргөдлийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Зах зээлд шинээр монополыг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсэж байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг)	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх			
6.Инновац болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Улсын төсвийн зардал нэмэгдэхгүй.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болсон.

10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	10.3.Инфляц нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн байдлаар зөрчилдөхгүй.

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ
(Хүснэгт 3)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. Бий болсон.
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ажлын байранд тогтвортой ажиллах сонирхол нэмэгдэнэ.
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Алба хаагчдын үүрэг хариуцлага сайжирна.
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. Ажлын байрны тодорхойлолт гарна.
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх			
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Төрийн байгууллагын хүлээх үүрэг, хариуцлага нэмэгдэнэ.
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Төрийн захиргааны зарим байгууллагын албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд өөрчлөлт орохгүй.
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөө үзүүлэхгүй
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ
(Хүснэгт 4)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт	Тайлбар
-------------------	---------------------	---------	---------

1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сэргээр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сэргээр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сэргээр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сэргээр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхыг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

6.1.2.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улс өөрийгөө хамгаалах зэвсэгт хүчинтэй байна. Зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалт, түүнд алба хаах журмыг хуулиар тогтооно.” гэж заасан байна.

Тус хуулийг шинэчлэн найруулснаар хууль боловсронгуй болж, хуулийн зохицуулалт сайжирч, эрх зүйн харилцаанд тодорхой өөрчлөлт гарах чухал нөлөө ач холбогдолтой.

Улсын нисэхийн тухай хуульд шинэчлэн найруулга хийснээр Монгол Улсын Үндсэн хууль болон хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээнд нийцэх бөгөөд хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжтой аливаа хэлбэрээр зөрчилдөхгүй болно.

-Мөн хууль санаачлагч Засгийн газрын Монгол Улсын Үндсэн хуулийн Арван нэгдүгээр зүйлийн 2-т “Монгол Улс өөрийгөө хамгаалах зэвсэгт хүчинтэй байна. Зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалт, түүнд алба хаах журмыг хуулиар тогтооно.” гэж, Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 6 дахь заалтад “улсыг батлан хамгаалах хүчин чадлыг бэхжүүлж, үндэсний аюулгүй байдлыг хангах” гэсэн эрх зүйн зохицуулалтын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын үндсэн бүрэн эрхийн хүрээнд хуулийн төслийг боловсруулах үйл ажиллагааны хууль зүйн үндэслэл хангагдах юм.

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ ХИЙСЭН БАЙДАЛ

Аргачлалын 7-д зааснаар хувилбаруудын эерэг болон сөрөг талуудыг

- Зорилгод хүрэх байдал;
- Зардал, үр өгөөжийн харьцаа;
- Хүний эрх, эдийн засагт, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө;
- Хууль тогтоомжтой нийцэж буй эсэх;
- Гарч болох сөрөг үр дагавар, түүнийг арилгах хувилбар байгаа эсэх гэсэн шалгуураар дахин нягтлан үзэж дараах дүгнэлтийг хийлээ.

Эрх зүйн орчныг сайжруулахын тулд боловсруулсан зохицуулалтуудын хувилбарт хүний эрхийг зөрчсөн зохицуулалт тусгагдаагүй болно.

Эдийн засгийн үр нөлөө, нийгэмд үзүүлэх үр нөлөө, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөний хувьд ямар нэгэн сөрөг үр нөлөө байхгүй, улсын төсвөөс зардал гарахгүй, төрийн байгууллагын үүрэг, хариуцлага улам нэмэгдэнэ.

ЗУРГАА. ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичгийн 6.2-т “Монгол Улсын батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны харилцааг зохицуулах хууль, эрх зүйн хэм хэмжээний цогц байдлыг хангана.” гэсэн, 8.2.2-т “агаарын орон зай, агаарын хилийн халдашгүй дархан байдалд хяналт тавих, хамгаалах” гэсэн, Зэвсэгт хүчний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.5-д “зэвсэгт хүчний бүх төрлийн хангалтыг төрөөс баталгаажуулах” гэсэн, мөн хуулийн 6.2.2-т “агаарын хилийн халдашгүй дархан байдал, агаарын зайд хяналт тавих, хамгаалах” зэрэг эрх зүйн зохицуулалт хангагдана.

Иймд Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 74-т “Улсын нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг боловсруулж, 2025 онд хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх гэж заасны хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дээрх харьцуулалтын үр дүнг харгалзан үзэж, тулгамдаж байгаа асуудлыг цогцоор шийдвэрлэх боломжийн хувьд дэвшүүлсэн хувилбаруудыг тус хуульд тусгаж, тус хуулийг төслийг шинэчилсэн найруулгын төслөөр боловсруулан хуулийг батлан хэрэгжүүлэх хувилбар илүү үр дүнд хүрэх юм.

Мөн хуулийн давхардсан, хийдсэн, зөрчигдсөн эрх зүйн зохицуулалтыг засаж холбогдох хууль тогтоомжтой нийцүүлэх асуудлуудыг Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга хийх замаар шийдвэрлэх юм.

---oOo---

УЛСЫН НИСЭХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТАД
ХИЙСЭН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭ

2025 он

АГУУЛГА

УДИРТГАЛ.....	3
НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	4
1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох нь	4
1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох	5
1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох	6
1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох	7
1.5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох	8-11
1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох	11
ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ.....	12
ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ	13
3.1. Улсын нисэхийн тухай хуулийн хэрэгжилтийг үнэлсэн байдал	
3.1.1. Зорилгод хүрсэн түвшин.....	14-18
3.1.2. Практикт нийцэж байгаа байдал	18-19
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	19-20
НОМ ЗҮЙ	21

УДИРТГАЛ

Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн 74 дэх хэсэг¹, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 4.4.3.4-т заасан “Хүртээмжтэй төсөв-Тогтвортой өсөлт” зорилтын хүрээнд Зэвсэгт хүчний бэлэн байдал, үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлж, төрийн цэргийг хөгжүүлж, бэхжүүлнэ.”² гэх зохицуулалтын хүрээнд хуулийн үйлчлэлд хамаарах улсын агаарын хөлөг эзэмшигч төрийн цэргийн байгууллагуудын үйл ажиллагааг нэгдсэн бодлого, удирдамжаар хангах, хяналт тавих зэрэг чиг үүргээ хэрэгжүүлэх үйл ажиллагааны зохицуулалтыг тодорхой болгох юм.

Улсын нисэхийн салбарт төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагын тоо, гүйцэтгэх үүргийн цар хүрээ, оролцоо өргөжиж, Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр улсын нисэхийн асуудал хариуцсан бүтцийн нэгж Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад байгуулагдсан болно.

Улсын нисэхийн хууль тогтоомж, бодлогын уялдаа холбоог хангах, хэрэгжилттэй холбоотой суудал, хүндрэл бэрхшээлийг арилгах, хэлтсийн үйл ажиллагаа, бодлогыг хэрэгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх, улсын агаарын хөлгөөр нислэг үйлдэх, улсын нисэхийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлыг хангах, улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагын албан хаагчид тавих мэргэжлийн чадвар, шаардлага, хариуцлагыг өндөржүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах ажил чухлаар тавигдаж байна.

Иймд хуулийн хэрэгжилтийн өнөөгийн байдлыг үнэлэх, цаашид бэхжүүлэх шаардлагыг тодорхойлох үүднээс Улсын нисэхийн тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх судалгааг хийх шаардлагатай гэж үзлээ.

Улсын нисэхийн тухай хуульд хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх судалгааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын зургаадугаар хавсралтаар батлагдсан хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын дагуу хийж, гүйцэтгэлээ.

¹ Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 181 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийг батлах тухай” 74 дэх хэсэг; холбоос: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17333392407821>

² Монгол Улсын Их Хурлын 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай”, 4.4.3.4-д заасан “Хүртээмжтэй төсөв-Тогтвортой өсөлт” зорилтын хүрээнд Зэвсэгт хүчний бэлэн байдал, үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлж, төрийн цэргийг хөгжүүлж, бэхжүүлнэ; холбоос: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17141368141311>

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Улсын нисэхийн тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх судалгааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн үндсэн гурван үе шаттайгаар хийж гүйцэтгэв.

Төлөвлөх үе шатанд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
4. Харьцуулах хэлбэрийг сонгох;
5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох;
6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.

1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох нь

Улсын Их Хурлаас Улсын нисэхийн тухай хуулийг анх 2003 онд баталж, нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, бусад хууль тогтоомжид нийцүүлэн 2004, 2013, 2015, 2018 болон 2023 онд тус тус нэмэлт, өөрчлөлт орсон.

Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн 74 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 4.4.3.4-д заасан “Хүртээмжтэй төсөв-Тогтвортой өсөлт” зорилтын хүрээнд Зэвсэгт хүчний бэлэн байдал, үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлж, төрийн цэргийг хөгжүүлж, бэхжүүлнэ.” гэж тусгасан.

Улсын нисэхийн тухай хуульд байлдааны агаарын хөлгийн нислэг, нисэх, инженер, техникчдийн бүрэлдэхүүн, улсын агаарын хөлгийн нислэгийн ангилал, нислэг үйлдэх, нисэх, инженер техникчдийн бүрэлдэхүүнийг батламжлах, бүртгэх, гэрчилгээжүүлэх, нисэхийн аюулгүй байдлын хяналт, дүрэм, журам, зааврыг уялдуулан зохицуулах, агаарын хөлгийг даатгалын асуудлыг зохицуулаагүй байгааг засах хэрэгцээ шаардлагатай байна. Үүнд:

-Улсын нисэхийн талаар хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын бүрэн эрх тодорхойлох

-Улсын нисэхийн салбарын хөгжлийг төрөөс дэмжих, гүйцэтгэх үүрэг, чадавхыг өргөжүүлэх асуудлыг зохицуулах;

-Улсын агаарын хөлгөөр нислэг үйлдэх, улсын нисэхийн орчинд үйл ажиллагаа явуулах гадаадын иргэн болон иргэний нисэхийн нисгэгч, инженер техникийн мэргэжлийн бүрэлдэхүүний зохицуулалтыг тусгах;

-Улсын нисэхийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан нислэгийн ангилалд улсын агаарын хөлгийн зарим байгууллагуудын үйл ажиллагаанд зохицоогүй, шаардлагатай хэмжээнд зохицуулагдаагүй байгааг тусгах;

-Улсын нисэхийн тухай хууль, улсын нисэхийн багц дүрмээс бусад дүрэм, журмуудыг улсын нисэхийн багц дүрмийн хүрээнд багцлах;

-Улсын нисэхийн асуудал хариуцсан бүтцийн нэгж Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бий болсонтой холбогдуулан Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрх, үүрэгт холбогдох эрх зүйн зохицуулалт бий болгож, хуулийн нийцлийг хангах;

-Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, тогтоомж, дүрмийн хүрээнд агаарын хөлгийн бүртгэл, гэрчилгээ, нисэхийн мэргэжлийн үнэмлэх, зэрэг, зэрэглэл олгох, батламжлах асуудлыг эрх зүйн хувьд тодорхой болгох хэрэгжилтийн өнөөгийн байдлыг үнэлэх, цаашид бэхжүүлэх шаардлагыг тодорхойлох нь зүйтэй.

1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох

Судалгааны үнэлгээний хүрээг тогтоох ажиллагаагаар нь хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлдог.

Үнэлгээний хүрээг үнэлгээ хийх болсон шалтгаантай харилцан уялдаа, хамааралтайгаар тогтооно. Ингэхдээ үнэлгээний хүрээгээр тодорхойлогдсон эерэг, сөрөг нөхцөл байдал, хүндрэл бэрхшээл, тулгамдсан асуудал, үр дагавар бүхий харилцаатай холбогдсон хуулийн зохицуулалтыг болон хуулиар зохицуулах шаардлагатай асуудлуудыг сонгоно. Ингэхдээ хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг болон хуульд заавал тусгах шаардлагатай асуудлуудыг сонгож болно.

Энэхүү судалгаагаар Улсын нисэхийн тухай хуульд тусгагдсан зарим зохицуулалт болон хуульд тусгах шаардлагатай зохицуулалтуудыг аль болох агуулгын хувьд бүхэлд нь тусгав. Үүнд:

1. Улсын нисэхийн тухай хууль

- Улсын нисэхийн тухай хуулийн 12 дугаар зүйл;³
- Улсын нисэхийн тухай хуулийн 16 дугаар зүйл;⁴

2. Хуульд тусгах шаардлагатай зохицуулалтууд

- Улсын нисэхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг;⁵
- Улсын нисэхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг;⁶
- Улсын нисэхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг;⁷

³ 12 дугаар зүйл. Улсын агаарын хөлөг байрлах аэродром

12.1. Улсын нисэхийн аэродром байгуулах, түүний бэлэн байдал, түүнд тавигдах шаардлагыг Улсын нисэхийн багц дүрмээр тогтооно.
12.2. Цэргийн зориулалттай нисэхийн аэродром байгуулах, түүний бэлэн байдал, түүнд тавигдах шаардлагыг тогтоох асуудлыг Зэвсэгт хүчний ерөнхий командлагатай зөвшилцөн Засгийн газар шийдвэрлэнэ.

12.3. Улсын нисэхийн аэродромын бүртгэлийг цэргийн мэргэжлийн удирдлагын дээд байгууллага эрхэлнэ. 12.4. Улсын нисэхийн аэродромын орчмын нутаг дэвсгэрийн гадна барилга байгууламж барих, холбооны болон өндөр хүчдэлийн шугам тавих асуудлыг батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай урьдчилан тохиролцож шийдвэрлэнэ.

⁴ 16 дугаар зүйл. Эрэн хайх, авран туслах үйл ажиллагаа

16.1. Аюул тулгарсан болон аюулд нэрвэгдсэн улсын агаарын хөлөг, нисэх баг, зорчигчдыг эрэн хайх, авран туслах үйл ажиллагааг цэргийн мэргэжлийн удирдлагын дээд байгууллага тухайн агаарын хөлөг эзэмшигчтэй хамтран тусгайлан бэлтгэгдсэн бие бүрэлдэхүүн, техник хэрэгсэл ашиглан гүйцэтгэнэ.

16.2. Эрэн хайх, авран туслах нислэгийг улсын болон иргэний нисэхийн байгууллагууд хамтран гүйцэтгэж болно.

16.3. Орон нутгийн засаг захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэд аюулд нэрвэгдсэн улсын агаарын хөлгийн талаар өөрт мэдэгдсэн мэдээллийг зохих байгууллагад нэн даруй мэдэгдэх, нисэх баг, зорчигчдын амь насыг аврах, тэдэнд эмнэлгийн болон бусад зайлшгүй тусламж үзүүлэх, түүнчлэн агаарын хөлөг, түүний баримт бичгийг хамгаалалтад авах үүрэгтэй.

⁵ 5.1. Улсын Их Хурал улсын нисэхийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 5.1.1. улсын нисэхийн салбарыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох;

5.1.2. улсын нисэхийн тухай хууль тогтоомжийг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих;

5.1.3. хуульд заасан бусад бүрэн эрх.

⁶ 6.1. Засгийн газар нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1. улсын нисэхийг хөгжүүлэх талаарх бодлого, арга хэмжээг зохион байгуулах, улсын нисэхийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;

6.1.2. улсын нисэхийн эрэн хайх, аврах үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээг чиглүүлэх;

6.1.3. улсын нисэхийн аэродром байгуулах, өөрчлөх, шилжүүлэх, бэлэн байдал, түүнд тавигдах шаардлагыг тогтоох;

6.1.4. улсын агаарын хөлөг, хөдөлгүүр болон газар дээрх дадлагажуур, тэдгээрийн эд анги, бүрэлдэхүүн хэсэг, дэд угсралтын хэсэг, сэлбэг, тоног төхөөрөмж, холбогдох хэрэгслийг гаалийн татвараас чөлөөлөх журмыг батлах;

6.1.5. Улсын нисэхийн нисгэгч, инженер техникчид болон нисэхийн тусгай мэргэжлийн бүрэлдэхүүний жагсаалт, цалингийн хэмжээ, итгэлцүүрийг тогтоох.

⁷ 7.1. Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1. улсын нисэхийн нислэгийн үйл ажиллагааны журмыг холбогдох байгууллагатай зөвшилцөж батлах;

- Улсын нисэхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг;⁸
- Улсын нисэхийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг;⁹
- Улсын нисэхийн тухай хуулийн 13 дугаар зүйл;¹⁰
- Улсын нисэхийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.5 дахь хэсэг;¹¹

1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох

“Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу Улсын нисэхийн тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийг үнэлэхэд оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байдлыг баримталж, мөн үнэлгээний хүрээ, онцлогоос хамааран дараах хоёр шалгуур үзүүлэлтийг сонгов. Үүнд:

1. Зорилгод хүрсэн түвшин;
2. Практикт нийцэж байгаа байдал.

I. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхэд зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийг хэрэглэх нь зохимжтой байдаг. Энэхүү онцлог нь тус судалгааны зорилгод нийцэж буй юм.

Мөн зорилгод хүрсэн түвшин нь хэдийгээр харьцангуй хийсвэр ч тус шалгуур үзүүлэлт нь хуулийн үйлчлэлийн үр нөлөөнд ерөнхий дүн шинжилгээ хийхэд чухал үүрэгтэй байдаг.

7.1.3.улсын нисэхийн багц дүрмийг батлах;

7.1.4.улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ерөнхий шинжээчийг томилно;

7.1.5.Улсын нисэхийн байцаагчийн эрх олгох;

7.1.6.Улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагын нисгэгч, нисэхийн тусгай мэргэжлийн бүрэлдэхүүний хүнсний хангалтын тусгай нормыг тогтоох.

⁸ 8.4.Улсын нисэхийн үйл ажиллагааг хариуцсан бүтцийн нэгж нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.4.1.улсын нисэхийн аюулгүй байдал, аюулгүй хамгаалалттай холбоотой хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх;

8.4.2.улсын нисэхийн аюулгүй байдал, аюулгүй хамгаалалттай холбоотой мэдээллийн санг хөтлөх, холбогдох байгууллагуудтай мэдээлэл солилцох;

8.4.3.улсын агаарын хөлөг, түүний бүрдэл хэсгийн гэрчилгээ, нисэхийн мэргэжлийн үнэмлэх, гэрчилгээ, зэрэг, зэрэглэл олгох, түдгэлзүүлэх, цуцлах;

8.4.4.улсын нисэхийн дүрэм болон бусад холбогдох эрх зүйн актыг боловсруулах, батлуулах, бүртгүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;

8.4.5.нислэгийн аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй Улсын нисэхийн дүрмээр зохицуулагдаагүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд тодорхой хугацаатай шийдвэр гаргаж, холбогдох этгээдэд мэдээлэх;

⁹ 10.2. Улсын нисэхийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

10.2.1.улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагын нисэхийн аюулгүй байдлыг хангуулна;

10.2.2.нисэхийн үйл ажиллагааг тасралтгүй, үр дүнтэй хэрэгжүүлэх мэргэжлийн хүний нөөцтэй байна;

10.2.3.Нислэгийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалтыг хангуулах нэгжтэй, харьяа нисэхийн анги, салбартай байна;

10.2.4. Улсын нисэхийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллагын нислэгийн үйл ажиллагаанд хяналт тавих шалгагч зэрэглэлтэй нисгэгч, инженерийг Улсын нисэхийн үйл ажиллагааг хариуцсан бүтцийн нэгжийн дүгнэлтийг үндэслэн томилох, чөлөөлөх;

¹⁰ 13 дугаар зүйл. Улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагын чиг үүрэг

13.1.Улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллага дараах үүрэгтэй:

13.1.1.энэ хууль, түүнтэй нийцүүлж баталсан эрх зүйн акт, эзэмшиж буй агаарын хөлгийн үйлдвэрлэгчээс гаргасан дүрэм, зааврын хүрээнд нислэгийн үйл ажиллагааг гүйцэтгэх;

13.1.2.нислэгийн аюулгүй байдлыг хангуулах чиглэлээр бүх төрлийн арга хэмжээг зохион байгуулах;

13.1.3.үүргээ гүйцэтгэж байгаа агаарын хөлгийн нисэх багийн амь нас,эрүүл мэндийг даатгуулна.

13.2.Улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллага нь нисэх онгоц, нисдэг тэрэгний дадлагажууртай байж болно.

13.3. Улсын нисэхийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах үүднээс улсын агаарын хөлгийг ашиглах гарын авлага, техник технологийн болон бусад холбогдох баримт бичгийг тухайн үйлдвэрлэгч орны хэл дээр ашиглаж болно.

¹¹ 19 дүгээр зүйл. Улсын нисэхийн аюулгүй байдлын хяналт

19.5. Улсын нисэхийн байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан нийтлэг бүрэн эрхээс гадна дараах бүрэн эрхтэй:

19.5.1.хяналт шалгалт хийх зорилгоор улсын нисэхийн үйл ажиллагаатай холбогдолтой объект, барилга байгууламжид саадгүй нэвтрэх;

19.5.2.улсын нисэхийн үйл ажиллагаатай холбоотой баримт бичгийн хувийг шаардан гаргуулах;

19.5.3.шаардлагатай тохиолдолд улсын агаарын хөлгийг саатуулах;

19.5.4.шаардлагатай тохиолдолд холбогдох этгээдийн улсын нисэхийн баримт бичгийг түр хураах;

Иймд Улсын нисэхийн тухай хууль болон хуулиар зохицуулах шаардлагатай асуудлуудыг сонгон зарим зүйл, заалтын хэрэгжилтийг үнэлэхэд тохиромжтой гэж үзлээ.

Энэхүү шалгуур үзүүлэлтээр Улсын нисэхийн тухай хуулийн зүйл, заалт нь хэрэгжиж эхэлснээс хойших хугацаандаа анх батлагдах үед төлөвлөсөн зорилгодоо хүрсэн эсэхийг тогтооно.

II. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

“Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд Улсын нисэхийн тухай хуулийн /шинэчилсэн найруулга/-ын зарим зүйл заалт практикт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг, сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл гарч байгаа эсэхийг тодорхойлохыг зорьсон.

1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхдээ түүний хэрэгжилттэй холбоотой үүссэн асуудал буюу үнэлэх болсон шалтгаан, тогтоосон хүрээ, шалгуур үзүүлэлтээс хамааран, аль болох тохиромжтой харьцуулах хэлбэрийг сонгодог. Харьцуулах доор дурдсан хэлбэрүүд байна. Үүнд:

- 1/ байх ёстой ба одоо байгаа;
- 2/ хууль батлагдахаас өмнөх ба хууль батлагдсанаас хойш;
- 3/ хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш;
- 4/тохиолдол судлах.

Дээрхээс “хууль батлагдахаас өмнөх ба хууль батлагдсанаас хойш”, “хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш”, “тохиолдол судлах” харьцуулах хэлбэрийг энэхүү судалгаанд тохиромжтой гэж үзэж сонгов.

“Хууль батлагдахаас өмнөх ба хууль батлагдсанаас хойш” харьцуулах хэлбэрээр Улсын нисэхийн тухай хуулийн зарим зүйл, заалт хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнөх нөхцөл байдлыг хууль тогтоомж, хүчин төгөлдөр хэрэгжсэний дараах нөхцөл байдал буюу хууль тогтоомжийн хэрэгжилтийн явцад гарч байгаа үр дагавартай харьцуулан дүн шинжилгээ хийхийг хэлнэ.

“Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш” харьцуулах хэлбэрээр Улсын нисэхийн тухай хуулийн зарим зүйл, заалт хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдсөнийг он дарааллаар судалж тогтооход чиглэгдэнэ.

“Тохиолдол судлах” харьцуулах хэлбэрээр Улсын нисэхийн тухай хуулийн зарим зүйл, заалт нь өөр өөр нөхцөл буюу тохиолдолд хэрхэн хэрэгжиж буй байдлыг харьцуулан дүн шинжилгээ хийхийг зорьсон.

1.5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох

“Шалгуур үзүүлэлтийг томъёолох” гэдэг нь сонгосон шалгуур үзүүлэлт тус бүрээр тодорхой таамаглал дэвшүүлэх буюу асуулт тавьдаг бөгөөд үнэлгээний хүрээнд хамаарах зохицуулалтад “зорилтод хүрсэн түвшин ямар байна вэ?”, “практикт хэрхэн нийцэж байна вэ?” гэх асуултын хүрээнд гүйцэтгэлээ.

Хүснэгт 1. Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлт.

Үнэлгээний хүрээ	Тогтоосон шалгуур үзүүлэлт	Харьцуулах хэлбэр	Шалгуур үзүүлэлт
	Зорилгод хүрсэн түвшин		
Улсын агаарын хөлөг байрлах аэродром. /Улсын нисэхийн тухай хуулийн 12 дугаар зүйл/	Тус хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Улсын нисэхийн аэродром байгуулах, түүний бэлэн байдал, түүнд тавигдах шаардлагыг Улсын нисэхийн багц дүрмээр тогтооно.” гэж, мөн зүйлийн 12.2-д “Цэргийн зориулалттай нисэхийн аэродром байгуулах, түүний бэлэн байдал, түүнд тавигдах шаардлагыг тогтоох асуудлыг Зэвсэгт хүчний ерөнхий командлагчтай зөвшилцөн Засгийн газар шийдвэрлэнэ.” гэж, мөн зүйлийн 12.3-д “Улсын нисэхийн аэродромын бүртгэлийг цэргийн мэргэжлийн удирдлагын дээд байгууллага эрхэлнэ.” мөн хуулийн 12.4-т “Улсын нисэхийн аэродромын орчмын нутаг дэвсгэрийн гадна барилга байгууламж барих, холбооны болон өндөр хүчдэлийн шугам тавих асуудлыг батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай урьдчилан тохиролцож шийдвэрлэнэ.” гэж тус тус хуульчилсан. Эдгээр зүйл, заалт нь Улсын нисэхийн тухай хуулиар хүлээсэн Улсын агаарын хөлөг байрлах аэродромын талаарх бодлого, арга хэмжээг зохион байгуулахад нийцэж байгаа эсэхэд үнэлэлт өгнө.	“Тохиолдол судлах” харьцуулалтын хэлбэрээр Улсын нисэхийн тухай хуулийн 12 дугаар зүйлд Улсын агаарын хөлөг байрлах аэродром нь мөн хуулийн зорилготой нийцэж, хууль тогтоомжтой зөрчилдөөгүй эсэхийг судална.	Улсын агаарын хөлөг байрлах аэродром нь хуулийн зорилгод нийцэж, хууль тогтоомжтой зөрчилдөөгүй байх.
Эрэн хайх, авран туслах үйл ажиллагаа. /Улсын нисэхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг/	Тус хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Аюул тулгарсан болон аюулд нэрвэгдсэн улсын агаарын хөлөг, нисэх баг, зорчигчдыг эрэн хайх, авран туслах үйл ажиллагааг цэргийн мэргэжлийн удирдлагын дээд байгууллага тухайн агаарын хөлөг эзэмшигчтэй хамтран тусгайлан бэлтгэгдсэн бие бүрэлдэхүүн, техник хэрэгсэл ашиглан гүйцэтгэнэ.” гэж, мөн зүйлийн 16.2-д “Эрэн хайх, авран туслах нислэгийг улсын болон иргэний нисэхийн байгууллагууд хамтран гүйцэтгэж болно.” гэж, мөн зүйлийн 16.3-д “Орон нутгийн засаг захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэд аюулд нэрвэгдсэн улсын агаарын хөлгийн талаар өөрт мэдэгдсэн мэдээллийг зохих байгууллагад нэн даруй мэдэгдэх, нисэх баг,	“Тохиолдол судлах” харьцуулалтын хэлбэрээр Улсын нисэхийн тухай хуулийн 16 дугаар зүйлд Эрэн хайх, авран туслах үйл ажиллагаа нь мөн хуулийн зорилготой нийцэж, хууль тогтоомжтой зөрчилдөөгүй эсэхийг судална.	Эрэн хайх, авран туслах үйл ажиллагаа нь хуулийн зорилгод нийцэж, хууль тогтоомжтой зөрчилдөөгүй байх.

	зорчигчдын амь насыг аврах, тэдэнд эмнэлгийн болон бусад зайлшгүй тусламж үзүүлэх, түүнчлэн агаарын хөлөг, түүний баримт бичгийг хамгаалалтад авах үүрэгтэй.” гэж тус тус хуульчилсан. Эдгээр зүйл, заалт нь Улсын нисэхийн тухай хуулиар хүлээсэн эрэн хайх, авран туслах ажлыг зохион байгуулах талаарх бодлого, арга хэмжээг зохион байгуулахад нийцэж байгаа эсэхэд үнэлэлт өгнө.		
--	---	--	--

Хүснэгт 2. Хуульд тусгах шаардлагатай зохицуулалт

Үнэлгээний хүрээ	Тогтоосон шалгуур үзүүлэлт	Харьцуулах хэлбэр	Шалгуур үзүүлэлт
	Зорилгод хүрсэн түвшин		
Улсын Их Хурлын бүрэн эрх. /Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг/	Тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Улсын Их Хурал улсын нисэхийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.” гэж, мөн зүйлийн 5.1.1-д “улсын нисэхийн салбарыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох;” гэж, мөн зүйлийн 5.1.2-д “улсын нисэхийн тухай хууль тогтоомжийг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих;” гэж мөн зүйлийн 5.1.3-д “хуульд заасан бусад бүрэн эрх.” гэж тус тус хуульчилсан. Эдгээр зүйл, заалт нь Улсын нисэхийн тухай хуулиар хүлээсэн бүрэн эрх, улсын нисэхийг хөгжүүлэх талаарх бодлого, арга хэмжээг зохион байгуулахад нийцэж байгаа эсэхэд үнэлэлт өгнө.	“Тохиолдол судлах” харьцуулалтын хэлбэрээр Улсын нисэхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан Улсын Их Хурлын бүрэн эрх нь мөн хуулийн зорилготой нийцэж, хууль тогтоомжтой зөрчилдөөгүй эсэхийг судална.	Улсын Их Хурлын бүрэн эрх нь хуулийн зорилгод нийцэж, хууль тогтоомжтой зөрчилдөөгүй байх.
Засгийн газрын бүрэн эрх /Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг/	Тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан бүрэн эрх нь Улсын нисэхийн тухай хуулиар хүлээсэн бүрэн эрх, улсын нисэхийг хөгжүүлэх талаарх бодлого, арга хэмжээг зохион байгуулахад нийцэж байгаа эсэхэд үнэлэлт өгнө.	“Тохиолдол судлах” харьцуулалтын хэлбэрээр Улсын нисэхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, дэх хэсэгт заасан Засгийн газрын бүрэн эрх нь мөн хуулийн зорилготой нийцэж байгаа эсэхийг судална.	Засгийн газрын бүрэн эрх нь хуулийн зорилгод нийцэж буй эсэх.
Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх /Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг/	Тус хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт заасан “Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.” нь Улсын нисэхийн тухай хуулиар хүлээсэн бүрэн эрх, улсын нисэхийг хөгжүүлэх талаарх бодлого, арга хэмжээг зохион байгуулахад нийцэж байгаа эсэхэд үнэлэлт өгнө	“Тохиолдол судлах” харьцуулалтын хэлбэрээр Улсын нисэхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан зохицуулсан Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх мөн хуулийн зорилготой нийцэж байгаа эсэхийг судална.	Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх нь хуулийн зорилгод нийцэж буй эсэх.

<p>Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг /Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 8 дугаар зүйлийн 8.4/</p>	<p>Тус хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-д заасан “Улсын нисэхийн үйл ажиллагааг хариуцсан бүтцийн нэгж нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.” нь Улсын нисэхийн тухай хуулиар хүлээсэн чиг үүрэг, улсын нисэхийг хөгжүүлэх талаарх бодлого, арга хэмжээг зохион байгуулахад нийцэж байгаа эсэхэд үнэлэлт өгнө</p>	<p>“Тохиолдол судлах” харьцуулалтын хэлбэрээр Улсын нисэхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-д Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг нь мөн хуулийн зорилготой нийцэж байгаа эсэхийг судална.</p>	<p>Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг нь хуулийн зорилгод нийцэж буй эсэх.</p>
<p>Улсын нисэхийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллагын чиг үүрэг /Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 10 дугаар зүйлийн 10.2/</p>	<p>Тус хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-д “Улсын нисэхийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.” нь Улсын нисэхийн тухай хуулиар хүлээсэн чиг үүрэг, улсын нисэхийг хөгжүүлэх талаарх бодлого, арга хэмжээг зохион байгуулахад нийцэж байгаа эсэхэд үнэлэлт өгнө</p>	<p>“Тохиолдол судлах” харьцуулалтын хэлбэрээр Улсын нисэхийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-д заасан Улсын нисэхийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллагын чиг үүрэг нь мөн хуулийн зорилготой нийцэж байгаа эсэхийг судална.</p>	<p>Улсын нисэхийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллагын чиг үүрэг нь хуулийн зорилгод нийцэж буй эсэх.</p>
<p>Улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагын чиг үүрэг /Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 13 дугаар зүйлийн 13.1/</p>	<p>Тус хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллага дараах үүрэгтэй.” 13.1.1-д “энэ хууль, түүнтэй нийцүүлж баталсан эрх зүйн акт, эзэмшиж буй агаарын хөлгийн үйлдвэрлэгчээс гаргасан дүрэм, зааврын хүрээнд нислэгийн үйл ажиллагааг гүйцэтгэх,” 13.1.2-д “нислэгийн аюулгүй байдлыг хангуулах чиглэлээр бүх төрлийн арга хэмжээг зохион байгуулах;” 13.1.3-д “үүргээ гүйцэтгэж байгаа агаарын хөлгийн нисэх багийн амь нас,эрүүл мэндийг даатгуулна.” гэж хуульчилсан. Улсын нисэхийн тухай хуулиар хүлээсэн чиг үүрэг, улсын нисэхийг хөгжүүлэх талаарх бодлого, арга хэмжээг зохион байгуулахад нийцэж байгаа эсэхэд үнэлэлт өгнө</p>	<p>“Тохиолдол судлах” харьцуулалтын хэлбэрээр Улсын нисэхийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д заасан Улсын нисэхийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллагын чиг үүрэг нь мөн хуулийн зорилготой нийцэж байгаа эсэхийг судална</p>	<p>Улсын нисэхийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллагын чиг үүрэг нь хуулийн зорилгод нийцэж буй эсэх.</p>

Хүснэгт 3. Практикт хүрсэн түвшин шалгуур үзүүлэлт.

<p>Үнэлгээний хүрээ</p>	<p>Тогтоосон шалгуур үзүүлэлт</p>	<p>Харьцуулах хэлбэр</p>	<p>Шалгуур үзүүлэлт</p>
	<p>Практикт хүрсэн түвшин шалгуур үзүүлэлт</p>		
<p>Улсын нисэхийн аюулгүй байдлын хяналт /Улсын нисэхийн тухай хуулийн</p>	<p>Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 19 дугаар зүйлийн 19.5-д “Улсын нисэхийн байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан нийтлэг бүрэн</p>	<p>“Тохиолдол судлах” харьцуулалтын хэлбэрээр Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 19 дугаар зүйлийн 19.5-р</p>	<p>Улсын нисэхийн аюулгүй байдлын хяналт эрх зүйн зохицуулалт практик хэрэгжиж байгаа эсэх.</p>

<p>шинэчилсэн найруулгын 19 дугаар зүйлийн 19.5/</p>	<p>эрхээс гадна дараах бүрэн эрхтэй.” 19.5.1-д “хяналт шалгалт хийх зорилгоор улсын нисэхийн үйл ажиллагаатай холбогдолтой объект, барилга байгууламжид саадгүй нэвтрэх;” 19.5.2-д “улсын нисэхийн үйл ажиллагаатай холбоотой баримт бичгийн хувийг шаардан гаргуулах;” 19.5.3-т “шаардлагатай тохиолдолд улсын агаарын хөлгийг саатуулах;” 19.5.4-д “шаардлагатай тохиолдолд холбогдох этгээдийн улсын нисэхийн баримт бичгийг түр хураах;” гэж хуульчилсан. Энэхүү зүйл заалтыг хэрэгжүүлэхэд ойлгомжтой бичигдэж чадсан эсэх, тус зүйлийг хэрэгжүүлснээр практикт ямар нэг сөрөг үр дагавар гарч байгаа эсэх буюу хэрэгжүүлэхэд асуудал үүсэж буй, үүсэж байсан тухай судлаачид хэрхэн үзэж байгаа талаар судална</p>	<p>зохицуулж буй эрх зүйн хэм хэмжээний практик хэрэгжилтийг судална.</p>	
--	--	---	--

1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Энэхүү судалгааны ажлын хүрээнд үнэлгээ хийх хуулийн зүйл, заалтын зорилгод хүрсэн түвшин, практик хэрэгжилтийг илрүүлэх зорилгоор шүүхийн шийдвэр буюу шүүхийн практик, энэхүү сэдвээр бичсэн эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл уншиж судлах, түүхчилсэн судалгаа хийх, харьцуулсан судалгаа хийх, судалгааны тайлан унших, харьцуулалт хийх, холбогдох байгууллагаас судалгааг гаргуулах зэрэг аргыг ашиглана.

Мэдээлэл цуглуулах аргын хувьд “Байгаа мэдээллийг цуглуулж ашиглах” аргыг сонгон хэрэгжүүллээ. Байгаа мэдээллийг цуглуулах хүрээнд тухайн чиглэлээр бичигдсэн холбогдох хууль тогтоомж, эрдэм шинжилгээний нэгэн сэдэвт бүтээл, гарын авлага, эрдэм шинжилгээний болон бусад хурлын эмхэтгэл, эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны тайланг цуглуулж үнэлгээ хийхэд ашигласан болно.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Улсын нисэхийн тухай хуулийн зарим зүйл заалтын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх судалгааны мэдээллийг цуглуулахдаа баримт бичгийн судалгаа, харьцуулсан судалгааны аргад тулгуурлан гүйцэтгэв.

Баримт бичгийн судалгаа: Улсын нисэхийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хууль тогтоомж, сурах бичиг, эрдэм шинжилгээний нэгэн сэдэвт бүтээл, гарын авлага, эрдэм шинжилгээний болон бусад хурлын эмхэтгэл, эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны тайланг цуглуулж үнэлгээ хийхэд ашигласан болно.

Тус судалгаанд ашигласан эх сурвалжийг судалгааны эх сурвалж хэсгээс харна уу.

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Энэхүү үнэлэх үе шатанд Улсын нисэхийн тухай хуулийн зарим зүйл заалтуудыг сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлнэ.

3.1. Улсын нисэхийн тухай хуулийн хэрэгжилтийг үнэлсэн байдал

3.1.1. Зорилгод хүрсэн түвшин

№	Үнэлгээ хийх хуулийн зүйл заалт	Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт
1	12 дугаар зүйл;	Зорилгод хүрсэн түвшин
2	16 дугаар зүйл;	Зорилгод хүрсэн түвшин

12 дугаар зүйл. Улсын агаарын хөлөг байрлах аэродром

12.1. Улсын нисэхийн аэродром байгуулах, түүний бэлэн байдал, түүнд тавигдах шаардлагыг Улсын нисэхийн багц дүрмээр тогтооно.

12.2. Цэргийн зориулалттай нисэхийн аэродром байгуулах, түүний бэлэн байдал, түүнд тавигдах шаардлагыг тогтоох асуудлыг Зэвсэгт хүчний ерөнхий командлагчтай зөвшилцөн Засгийн газар шийдвэрлэнэ.

12.3. Улсын нисэхийн аэродромын бүртгэлийг цэргийн мэргэжлийн удирдлагын дээд байгууллага эрхэлнэ.

12.4. Улсын нисэхийн аэродромын орчмын нутаг дэвсгэрийн гадна барилга байгууламж барих, холбооны болон өндөр хүчдэлийн шугам тавих асуудлыг батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай урьдчилан тохиролцож шийдвэрлэнэ.

16 дугаар зүйл. Эрэн хайх, авран туслах үйл ажиллагаа

16.1. Аюул тулгарсан болон аюулд нэрвэгдсэн улсын агаарын хөлөг, нисэх баг, зорчигчдыг эрэн хайх, авран туслах үйл ажиллагааг цэргийн мэргэжлийн удирдлагын дээд байгууллага тухайн агаарын хөлөг эзэмшигчтэй хамтран тусгайлан бэлтгэгдсэн бие бүрэлдэхүүн, техник хэрэгсэл ашиглан гүйцэтгэнэ.

16.2. Эрэн хайх, авран туслах нислэгийг улсын болон иргэний нисэхийн байгууллагууд хамтран гүйцэтгэж болно.

16.3. Орон нутгийн засаг захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэд аюулд нэрвэгдсэн улсын агаарын хөлгийн талаар өөрт мэдэгдсэн мэдээллийг зохих байгууллагад нэн даруй мэдэгдэх, нисэх баг, зорчигчдын амь насыг аврах, тэдэнд эмнэлгийн болон бусад зайлшгүй тусламж үзүүлэх, түүнчлэн агаарын хөлөг, түүний баримт бичгийг хамгаалалтад авах үүрэгтэй.

№	Үнэлгээ хийх хуулийн зүйл заалт	Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт
1	5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг;	Зорилгод хүрсэн түвшин
2	6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг;	Зорилгод хүрсэн түвшин
3	7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг;	Зорилгод хүрсэн түвшин
4	8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг;	Зорилгод хүрсэн түвшин
5	10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг;	Зорилгод хүрсэн түвшин
6	13 дүгээр зүйлийн 13.1 дэх хэсэг.	Зорилгод хүрсэн түвшин

5 дугаар зүйл.Улсын Их Хурлын бүрэн эрх

5.1.Улсын Их Хурал улсын нисэхийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 5.1.1.улсын нисэхийн салбарыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох;
- 5.1.2.улсын нисэхийн тухай хууль тогтоомжийг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих;
- 5.1.3.хуульд заасан бусад бүрэн эрх.

6 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх

6.1.Засгийн газар нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 6.1.1.улсын нисэхийг хөгжүүлэх талаарх бодлого, арга хэмжээг зохион байгуулах, улсын нисэхийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;
- 6.1.2.улсын нисэхийн эрэн хайх, аврах үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээг чиглүүлэх;
- 6.1.3.улсын нисэхийн аэродром байгуулах, өөрчлөх, шилжүүлэх, бэлэн байдал, түүнд тавигдах шаардлагыг тогтоох;
- 6.1.4.улсын агаарын хөлөг, хөдөлгүүр болон газар дээрх дадлагажуур, тэдгээрийн эд анги, бүрэлдэхүүн хэсэг, дэд угсралтын хэсэг, сэлбэг, тоног төхөөрөмж, холбогдох хэрэгслийг гаалийн татвараас чөлөөлөх журмыг батлах;
- 6.1.5.Улсын нисэхийн нисгэгч, инженер техникчид болон нисэхийн тусгай мэргэжлийн бүрэлдэхүүний жагсаалт, цалингийн хэмжээ, итгэлцүүрийг тогтоох.

7 дугаар зүйл.Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх

7.1.Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 7.1.1.улсын нисэхийн нислэгийн үйл ажиллагааны журмыг холбогдох байгууллагатай зөвшилцөж батлах;
- 7.1.3.улсын нисэхийн багц дүрмийг батлах;
- 7.1.4.улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ерөнхий шинжээчийг томилно;
- 7.1.5.Улсын нисэхийн байцаагчийн эрх олгох;
- 7.1.6.Улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагын нисгэгч, нисэхийн тусгай мэргэжлийн бүрэлдэхүүний хүнсний хангалтын тусгай нормыг тогтоох.

8 дугаар зүйл.Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг

8.4.Улсын нисэхийн үйл ажиллагааг хариуцсан бүтцийн нэгж нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 8.4.1.улсын нисэхийн аюулгүй байдал, аюулгүй хамгаалалттай холбоотой хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх;
 - 8.4.2.улсын нисэхийн аюулгүй байдал, аюулгүй хамгаалалттай холбоотой мэдээллийн санг хөтлөх, холбогдох байгууллагуудтай мэдээлэл солилцох;
 - 8.4.3.улсын агаарын хөлөг, түүний бүрдэл хэсгийн гэрчилгээ, нисэхийн мэргэжлийн үнэмлэх, гэрчилгээ, зэрэг, зэрэглэл олгох, түдгэлзүүлэх, цуцлах;
 - 8.4.4.улсын нисэхийн дүрэм болон бусад холбогдох эрх зүйн актыг боловсруулах, батлуулах, бүртгүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;
 - 8.4.5.нислэгийн аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй Улсын нисэхийн дүрмээр зохицуулагдаагүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд тодорхой хугацаатай шийдвэр гаргаж, холбогдох этгээдэд мэдээлэх;
- техникчид болон нисэхийн тусгай мэргэжлийн бүрэлдэхүүний жагсаалт, цалингийн хэмжээ,

10 дүгээр зүйл. Улсын нисэхийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллагын чиг үүрэг

10.2. Улсын нисэхийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

10.2.1. улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагын нисэхийн аюулгүй байдлыг хангуулна;

10.2.2. нисэхийн үйл ажиллагааг тасралтгүй, үр дүнтэй хэрэгжүүлэх мэргэжлийн хүний нөөцтэй байна;

10.2.3. Нислэгийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалтыг хангуулах нэгжтэй, харьяа нисэхийн анги, салбартай байна;

10.2.4. Улсын нисэхийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллагын нислэгийн үйл ажиллагаанд хяналт тавих шалгагч зэрэглэлтэй нисгэгч, инженерийг Улсын нисэхийн үйл ажиллагааг хариуцсан бүтцийн нэгжийн дүгнэлтийг үндэслэн томилох, чөлөөлөх;

13 дугаар зүйл. Улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагын чиг үүрэг

13.1. Улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллага дараах үүрэгтэй:

13.1.1. энэ хууль, түүнтэй нийцүүлж баталсан эрх зүйн акт, эзэмшиж буй агаарын хөлгийн үйлдвэрлэгчээс гаргасан дүрэм

, зааврын хүрээнд нислэгийн үйл ажиллагааг гүйцэтгэх;

13.1.2. нислэгийн аюулгүй байдлыг хангуулах чиглэлээр бүх төрлийн арга хэмжээг зохион байгуулах;

13.1.3. үүргээ гүйцэтгэж байгаа агаарын хөлгийн нисэх багийн амь нас, эрүүл мэндийг даатгуулна.

13.2. Улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллага нь нисэх онгоц, нисдэг тэрэгний дадлагажууртай байж болно.

13.3. Улсын нисэхийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах үүднээс улсын агаарын хөлгийг ашиглах гарын авлага, техник технологийн болон бусад холбогдох баримт бичгийг тухайн үйлдвэрлэгч орны хэл дээр ашиглаж болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван нэгдүгээр зүйлийн 1-д “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн” гэж, мөн зүйлийн 2-т “Монгол Улс өөрийгөө хамгаалах зэвсэгт хүчинтэй байна. Зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалт, түүнд алба хаах журмыг хуулиар тогтооно.” гэж, Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 6 дахь заалтад “улсыг батлан хамгаалах хүчин чадлыг бэхжүүлж, үндэсний аюулгүй байдлыг хангах” гэж;

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Тавдугаар зүйлийн Зорилт 5.2-т “Төрийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тодорхойлох замаар чиг үүрэг, эрх мэдлийн хуваарилалтыг нарийвчилна” гэж;

-Монгол Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичгийн 6.2-т “Монгол Улсын батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны харилцааг зохицуулах хууль, эрх зүйн хэм хэмжээний цогц байдлыг хангана” гэж;

-Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 4.1.2-т “Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж,

ажил үүргийн давхцал, хийдлийг арилгаж, харилцан зохицуулалт хийх механизмыг боловсронгуй болгоно” гэж;

-Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1-д “батлан хамгаалах бодлого, тогтолцооны эрх зүйн үндсийг тогтоох” гэж Улсын Их Хурлын бүрэн эрхэд;

-Зэвсэгт хүчний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 12.1.2-т “зэвсэгт хүчний чадавхыг нэмэгдүүлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх” гэж Засгийн газрын бүрэн эрхэд тус тус заажээ.

Дээрх зохицуулалтын хүрээнд хуулийн 12 дугаар зүйл, 16 дугаар зүйлд заасан зохицуулалтуудыг үзвэл:

1.Улсын нисэхийн Улсын агаарын хөлөг байрлах аэродром, Эрэн хайх, авран туслах үйл ажиллагаа нь:

-Улсын нисэхийн аэродром байгуулах, түүний бэлэн байдал, түүнд тавигдах шаардлагыг Улсын нисэхийн багц дүрмээр тогтооно.

-Цэргийн зориулалттай нисэхийн аэродром байгуулах, түүний бэлэн байдал, түүнд тавигдах шаардлагыг тогтоох асуудлыг Зэвсэгт хүчний ерөнхий командлагчтай зөвшилцөн Засгийн газар шийдвэрлэнэ.

-Улсын нисэхийн аэродромын бүртгэлийг цэргийн мэргэжлийн удирдлагын дээд байгууллага эрхэлнэ.

-Улсын нисэхийн аэродромын орчмын нутаг дэвсгэрийн гадна барилга байгууламж барих, холбооны болон өндөр хүчдэлийн шугам тавих асуудлыг батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай урьдчилан тохиролцож шийдвэрлэнэ.

Улсын нисэхийн аэродром байгуулах шаардлагатай зохицуулалтыг Улсын нисэхийн багц дүрмээр зохицуулах бөгөөд цэргийн зориулалттай нисэхийн аэродром байгуулах асуудлыг Зэвсэгт хүчний ерөнхий командлагчтай зөвшилцсөний үндсэн дээр Засгийн газар шийдвэр гарган, бүртгэлийг цэргийн мэргэжлийн удирдлагын дээд байгууллага хэрэгжүүлж аэродромын орчмын нутаг дэвсгэрийн гадна барилга байгууламж барих, холбооны болон өндөр хүчдэлийн шугам тавих асуудлыг батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай урьдчилан тохиролцож шийдвэр гаргах ач холбогдолтой.

-Аюул тулгарсан болон аюулд нэрвэгдсэн улсын агаарын хөлөг, нисэх баг, зорчигчдыг эрэн хайх, авран туслах үйл ажиллагааг цэргийн мэргэжлийн удирдлагын дээд байгууллага тухайн агаарын хөлөг эзэмшигчтэй хамтран тусгайлан бэлтгэгдсэн бие бүрэлдэхүүн, техник хэрэгсэл ашиглан гүйцэтгэнэ.

-Эрэн хайх, авран туслах нислэгийг улсын болон иргэний нисэхийн байгууллагууд хамтран гүйцэтгэж болно.

-Орон нутгийн засаг захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэд аюулд нэрвэгдсэн улсын агаарын хөлгийн талаар өөрт мэдэгдсэн мэдээллийг зохих байгууллагад нэн даруй мэдэгдэх, нисэх баг, зорчигчдын амь насыг аврах, тэдэнд эмнэлгийн болон бусад зайлшгүй тусламж үзүүлэх, түүнчлэн агаарын хөлөг, түүний баримт бичгийг хамгаалалтад авах үүрэгтэй.

Аюул тулгарсан болон аюулд нэрвэгдсэн улсын агаарын хөлөг, нисэх баг, зорчигчдыг эрэн хайх, авран туслах үйл ажиллагааг зохион байгуулах байгууллага

болон хамтран ажиллах байгууллагыг тодорхой тусгасан бөгөөд орон нутаг, аж ахуйн нэгж, иргэд аюулд нэрвэгдсэн мэдээллийг нэн даруй мэдэгдэх, эмнэлгийн болон бусад зайлшгүй тусламж үзүүлэх, агаарын хөлөг, түүний баримт бичгийг хамгаалалтад авах үүргийг тусгасан байна.

Мөн Улсын нисэхийн тухай хуульд тусгах шаардлагатай зохицуулалтыг үзвэл:

2.Улсын нисэхийн эрх зүйн орчныг боловсронгуй болгож, улсын нисэхийн үйл ажиллагаанд төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллагын нисэхийн аюулгүй байдалтай холбоотой хүлээх эрх, үүрэг нь:

- улсын нисэхийн салбарыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох, улсын нисэхийн тухай хууль тогтоомжийг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих талаар *“Улсын Их Хурал”*

- улсын нисэхийг хөгжүүлэх талаарх бодлого, арга хэмжээг зохион байгуулах, улсын нисэхийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, улсын нисэхийн эрэн хайх, аврах үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээг чиглүүлэх, улсын нисэхийн аэродром байгуулах, өөрчлөх, шилжүүлэх, бэлэн байдал, түүнд тавигдах шаардлагыг тогтоох, улсын агаарын хөлөг, хөдөлгүүр болон газар дээрх дадлагажуур, тэдгээрийн эд анги, бүрэлдэхүүн хэсэг, дэд угсралтын хэсэг, сэлбэг, тоног төхөөрөмж, холбогдох хэрэгслийг гаалийн татвараас чөлөөлөх журмыг батлах, Улсын нисэхийн нисгэгч, инженер техникчид болон нисэхийн тусгай мэргэжлийн бүрэлдэхүүний жагсаалт, цалингийн хэмжээ, итгэлцүүрийг тогтоох талаар *“Засгийн газрын бүрэн эрх”*

- улсын нисэхийн нислэгийн үйл ажиллагааны журмыг холбогдох байгууллагатай зөвшилцөж батлах, улсын нисэхийн багц дүрмийг батлах, улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ерөнхий шинжээчийг томилно, Улсын нисэхийн байцаагчийн эрх олгох, Улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагын нисгэгч, нисэхийн тусгай мэргэжлийн бүрэлдэхүүний хүнсний хангалтын тусгай нормыг тогтоох талаар *“Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх”*

- улсын нисэхийн аюулгүй байдал, аюулгүй хамгаалалттай холбоотой хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх, улсын нисэхийн аюулгүй байдал, аюулгүй хамгаалалттай холбоотой мэдээллийн санг хөтлөх, холбогдох байгууллагуудтай мэдээлэл солилцох, улсын агаарын хөлөг, түүний бүрдэл хэсгийн гэрчилгээ, нисэхийн мэргэжлийн үнэмлэх, гэрчилгээ, зэрэг, зэрэглэл олгох, түдгэлзүүлэх, цуцлах, улсын нисэхийн дүрэм болон бусад холбогдох эрх зүйн актыг боловсруулах, батлуулах, бүртгүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, нислэгийн аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй Улсын нисэхийн дүрмээр зохицуулагдаагүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд тодорхой хугацаатай шийдвэр гаргаж, холбогдох этгээдэд мэдээлэх талаар *“Улсын нисэхийн үйл ажиллагааг хариуцсан бүтцийн бүрэн эрх”*

- улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагын нисэхийн аюулгүй байдлыг хангуулна, нисэхийн үйл ажиллагааг тасралтгүй, үр дүнтэй хэрэгжүүлэх мэргэжлийн хүний нөөцтэй байна, Нислэгийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалтыг хангуулах нэгжтэй, харьяа нисэхийн анги, салбартай байна, Улсын нисэхийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллагын нислэгийн үйл ажиллагаанд хяналт тавих шалгагч зэрэглэлтэй нисгэгч, инженерийг Улсын нисэхийн үйл ажиллагааг хариуцсан

бүтцийн нэгжийн дүгнэлтийг үндэслэн томилох, чөлөөлөх талаар “Улсын нисэхийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллагын чиг үүрэг”

- энэ хууль, түүнтэй нийцүүлж баталсан эрх зүйн акт, эзэмшиж буй агаарын хөлгийн үйлдвэрлэгчээс гаргасан дүрэм, зааврын хүрээнд нислэгийн үйл ажиллагааг гүйцэтгэх, нислэгийн аюулгүй байдлыг хангуулах чиглэлээр бүх төрлийн арга хэмжээг зохион байгуулах, үүргээ гүйцэтгэж байгаа агаарын хөлгийн нисэх багийн амь нас, эрүүл мэндийг даатгуулах талаар “Улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагын үүрэг”

Улсын нисэхийн салбарт төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагын тоо, гүйцэтгэх үүргийн цар хүрээ, оролцоо өргөжиж байгаа болон Улсын нисэхийн асуудал хариуцсан бүтцийн нэгж Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад байгуулагдсантай холбогдуулан Улсын нисэхийн хууль тогтоомж, бодлогын хэрэгжилттэй холбоотой асуудал, хүндрэл бэрхшээлийг арилгах, улсын агаарын хөлгөөр нислэг үйлдэх, улсын нисэхийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлыг хангах, улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагын албан хаагчид тавих мэргэжлийн чадвар, шаардлага, хариуцлагыг өндөржүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах ажил чухлаар тавигдаж байна.

Улсын нисэхийн үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтууд нэмж, хуулийн зарим зохицуулалтад өөрчлөн найруулснаар эрх бүхий байгууллага, албан тушаалтны эрх, үүрэг хэм хэмжээг тодорхойлох, улсын нисэхийн үйл ажиллагаа, зохион байгуулалтыг нэгдсэн удирдлагаар хангах болон улсын агаарын хөлгийн бүртгэл, улсын агаарын хөлгийн дарга, нисэх баг, нислэгийн ангилал, эрэн хайх, авран туслах болон шинээр худалдан авсан хүн тээврийн агаарын хөлгийг даатгалжуулах үйл ажиллагаа хууль тогтоомжоор зохицуулагдах юм.

3.1.2. Практикт нийцэж байгаа байдал

19 дүгээр зүйл. Улсын нисэхийн аюулгүй байдлын хяналт

19.5. Улсын нисэхийн байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан нийтлэг бүрэн эрхээс гадна дараах бүрэн эрхтэй:

19.5.1. хяналт шалгалт хийх зорилгоор улсын нисэхийн үйл ажиллагаатай холбогдолтой объект, барилга байгууламжид саадгүй нэвтрэх;

19.5.2. улсын нисэхийн үйл ажиллагаатай холбоотой баримт бичгийн хувийг шаардан гаргуулах;

19.5.3. шаардлагатай тохиолдолд улсын агаарын хөлгийг саатуулах;

19.5.4. шаардлагатай тохиолдолд холбогдох этгээдийн улсын нисэхийн баримт бичгийг түр хураах;

Улсын нисэхийн аюулгүй байдлын хяналт дараах механизмыг бүрдүүлсэн. Үүнд:

Хэрэгжилтийг хянах механизмын хүрээнд хуулийн 19 дугаар зүйлийн 19.5 дэх хэсэгт Улсын нисэхийн байцаагч нь хяналт тавих мэргэжлийн чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан, дээд боловсролтой, улсын нисэхийн олон улсын эрх зүйн зохицуулалтын зохих мэдлэг, ур чадвартай байх тухай зохицуулалтыг тусгасан байна.

Ийнхүү хуульчилсны дагуу хуулийн хэрэгжилтийг хянах механизм практикт хэрхэн хэрэгжих талаар судлахад:

1. Улсын нисэхийн аюулгүй ажиллагааг хангах, хуульд заасан нислэг-техникийн осол, зөрчлийг шалгах ерөнхий шинжээчийг томилох, албан тушаалын

харьяаллыг тодорхой болгох, нисэхийн үйл ажиллагаа Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нэгжийн бүрэн эрхэд Улсын нисэхтэй холбоотой эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгож баримтлах үндэслэлийг тусгаж өөрчлөхөөс гадна Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 486 дугаар тогтоолоор улсын нисэхтэй холбоотой хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтийг боловсронгуй болгох, улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагуудыг бодлогын нэгдсэн удирдлагаар хангах, нисэхийн аюулгүй байдалд хяналт тавих, зохицуулалтын тогтолцоог сайжруулах зэрэг асуудлуудыг тусгах зэрэг зүй ёсны шаардлага байгаа болно.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

4.1. Улсын нисэхийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн дүгнэлт, зөвлөмж

Зорилгод хүрсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд

Нисэхийн салбарт төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагын тоо, гүйцэтгэх үүргийн цар хүрээ, оролцоо өргөжиж байгаатай уялдуулан Улсын нисэхийн асуудал хариуцсан бүтцийн нэгж Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад шилжин байгуулагдсантай холбогдуулан Улсын нисэхийн хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгийн уялдаа холбоог сайжруулах, хуулийн хийдсэн, давхардсан, зөрчигдсөн байдлыг арилгах, улсын агаарын хөлгөөр нислэг үйлдэх, улсын нисэхийн аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлыг хангах, улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагын албан хаагчид тавих мэргэжлийн шалгуур үзүүлэлт, шаардлага, хариуцлагыг өндөржүүлэх, эрх зүйн баталгааг бүрдүүлэх болон Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хууль, Иргэний нисэхийн тухай хуулиуд шинэчлэн батлагдсантай нийцүүлэн Улсын нисэхийн тухай хууль /шинэчлэн найруулах/-ийн төслийг боловсруулах эрх зүйн хэрэгцээ, шаардлага бий болсон.

Мөн сүүлийн жилүүдэд Улсын нисэхийн тухай хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд (Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлал, Онцгой байдлын Ерөнхий газар, Хил хамгаалах Ерөнхий газар)-ыг улсын агаарын хөлгөөр хангах, хуульд заасан чиг үүргээ гүйцэтгэх боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр Засгийн газраас бүх талаар дэмжин ажиллаж байна. Тухайлбал, 2020 оноос хойших хугацаанд Зэвсэгт хүчний Агаарын цэрэг 7, Хил хамгаалах Ерөнхий газар 1, Онцгой байдлын Ерөнхий газар 4 нэгж агаарын хөлгөөр хүчин чадлаа нэмэгдүүлжээ.

Улсын нисэхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, холбогдох хууль тогтоомжтой нийцүүлэн боловсронгуй болгож, зарим эрх зүйн харилцааг нарийвчлан тодорхойлох замаар хуулийг илүү боловсронгуй, ойлгомжтой зөв хэрэглэх дараах хэрэгцээ шаардлага байгаа болно. Үүнд:

1. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулиудад улсын агаарын хөлөг эзэмшигч байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулахтай холбогдсон харилцааг тухайлан тусгаагүй байдаг тул хуулийн төслөөр Улсын Их Хурал, Засгийн газрын бүрэн эрхэд улсын нисэхийн үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зарим зохицуулалтуудыг тусгах шаардлагатай.

2. Сүүлийн жилүүдэд улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагууд шинэ төрлийн агаарын хөлгөөр нислэгийн үйл ажиллагаа эрхлэх, үйл ажиллагаандаа олон улсын эрх бүхий байгууллагаас гэрчилгээжсэн гадаадын иргэн болон Монгол Улсын иргэний нисэх, бусад хувийн нисэхийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуй нэгж, иргэдтэй хамтран ажиллах болсон нь хүчин төгөлдөр мөрдөж байгаа Улсын нисэхийн тухай хуульд энэ талаарх тусгайлсан эрх зүйн зохицуулалт дутмаг байгааг засаж, энэ талаар эрх зүйн зохицуулалтыг хуульд тусгайлан шинээр нэмэх хэрэгцээ үүссэн.

3. Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад улсын нисэхийн асуудал хариуцсан бүтцийн нэгж шинээр бий болсонтой холбоотойгоор хуульд улсын агаарын хөлгийн бүртгэл, нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгох, цуцлах, сунгах болон нисэх, инженер техникчдийн бүрэлдэхүүнд нисэхийн мэргэжлийн үнэмлэх, зэрэглэл, зэрэг олгох, сунгах, батламжлах болон агаарын хөлгийг даатгалд хамааруулахтай холбогдсон харилцааг хуулиар тодорхой зохицуулалттай болгох шаардлага байна.

Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсанаар улсын нисэхийн үйл ажиллагаа, түүний удирдлага, чиг үүрэг тодорхой болж, хуулийг зөв ойлгомжтой хэрэглэх, хуулийг хэрэгжүүлэх бусад эрх зүйн баримт бичгүүд боловсронгуй болж, давхцал, хийдэл бүрэн арилах боломж бүрдэнэ.

НОМ ЗҮЙ

НЭГ. Монгол Улсын хууль

1. Улсын нисэхийн тухай хууль, (2003 он);
2. Захиргааны ерөнхий хууль, (2015 он);
3. Хууль тогтоомжийн тухай хууль, (2015 он);
4. Иргэний нисэхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, (2023 он).

ХОЁР. Хэм хэмжээний акт

1. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Алсын хараа-2050”;
2. Монгол Улсын Их Хурлын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай”;
3. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай”;
4. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолоор баталсан “Аргачлал батлах тухай” ;

ГУРАВ. Монгол хэл дээрх ном, өгүүлэл, нийтлэл, судалгааны тайлан, эмхэтгэл

1. Вокдушный Кодекс Российской Федерации;
2. Об использовании Вокдушного пространства Республики Казахстан деятельности авиаций.

УЛСЫН НИСЭХИЙН ТУХАЙ ХУУЛЬ
/ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙН ТӨСЛИЙН
ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2025 ОН

ТАЙЛАН

Нэг.Ерөнхий зүйл

Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийж, түүний үр нөлөөг тооцож, хуулийн төслийг боловсронгуй болгоход энэхүү үнэлгээний ажлын зорилго оршино.

Энэхүү үнэлгээг Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл (цаашид “хуулийн төсөл” гэх)-ийн зүйл, хэсэгт Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг илрүүлэн, хуулийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад зөвлөмж өгөх зорилгоор гүйцэтгэв.

Үнэлгээ хийхээр сонгож авсан хуулийн төсөл нь хуулийн шинэчлэн найруулсан төсөл хэлбэрээр боловсруулагдсан байна.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал” (цаашид “Аргачлал” гэх)-д заасны дагуу дараах үе шатаар хийлээ.

- 1.Шалгуур үзүүлэлтийг сонгох;
- 2.Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
- 3.Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
- 4.Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

Хоёр. Хуулийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгосон байдал

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах харилцаатай уялдуулан Аргачлалын 2.9-д заасныг үндэслэн 6 шалгуур үзүүлэлтээс зорилгод хүрэх байдал, практикт хэрэгжих боломж, ойлгомжтой байдал, харилцан уялдаа зэрэг 4 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

Шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл буюу шалгуур үзүүлэлтүүд:

1.“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд Хуулийн төслийн зорилго нь үзэл баримтлалд тусгасан хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцэж байгаа байдал, хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтууд нь хуулийн төслийн зорилгод хүрэх боломжтой байдлаар томъёологдсон эсэхийг үнэллээ.

Тус үнэлгээг хийхдээ хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага, хуулийн төслийн зорилго болон зорилгод хүрэхэд чиглэгдсэн, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц арга хэмжээ, зохицуулалтыг сонгож авсан болно.

2.“Практикт хэрэгжих боломж” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зүйл, заалтууд нь тэдгээрийг дагаж мөрдөх болон хэрэгжүүлэх албан тушаалтан, этгээдэд тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, нөхцөл байгаа эсэхийг үнэлэхээр сонгосон болно.

3.“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь хэрэглэх, хэрэгжүүлэхэд Хууль тогтоомжийн тухай хууль, холбогдох аргачлалд заасан шаардлагыг хангасан, зөв томъёолсон эсэхийг үнэлэхээр сонгосон болно.

4.“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт өөр хоорондоо болон Монгол Улсын Үндсэн хууль, холбогдох бусад хуульд нийцсэн эсэхийг Аргачлалд заасан асуултад хариулах байдлаар үнэлгээ хийхээр тооцов.

Гурав. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу төслийн үр нөлөөг үнэлсэн байдал

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилгыг хангах эсэхийг судлах.
2	Практикт хэрэгжих боломж	Хуулийн төслийн 5, 6, 7, 8, 9 дүгээр зүйл	Хуулийн төслийн холбогдох зохицуулалт нь бодит байдал дээр хэрэгжих боломжтой эсэхийг судлах.
3	Ойлгомжтой байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйл, холбогдох аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэх.
4	Харилцан уялдаа	Хуулийн төсөл бүхэлдээ	Хуулийн төсөлд тавигдах нийтлэг шаардлагыг хангасан эсэх.

3.1.“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалд тодорхойлсноор хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлбэрээр боловсруулна.

Хуулийн төсөлд Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын зорилтыг Монгол Улсын нутаг дэвсгэр, агаарын зайд улсын агаарын хөлгөөр нислэг үйлдэх, улсын нисэхийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахаар томъёолжээ.

Мөн Улсын нисэхийн удирдлага, улсын нисэхийн үйл ажиллагааны зохицуулалт, улсын агаарын хөлөг, түүнд хамаарах үйл ажиллагаа, улсын нисэхийн аэродромын ашиглалт, нислэгийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалт, улсын агаарын хөлгийг эрэн хайх, авран туслах ажил, улсын нисэхийн нислэг-техникийн осол зөрчлийг шинжлэн шалгах зэрэг зохицуулалтуудыг бүлэг болгон тус тус тусгасан.

Түүнчлэн Улсын нисэхийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллага болох Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлаг, тэдгээрийн улсын нисэхийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалт, хяналт зохицуулалтыг хэрэгжүүлэх чиг үүргийг тодорхой тусгасан.

Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын үйлчлэлд хамаарах байгууллагууд (Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлал, Онцгой байдлын Ерөнхий газар, Хил хамгаалах Ерөнхий газар)-ыг улсын агаарын хөлгөөр хангах, хуульд заасан чиг үүргээ гүйцэтгэх боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр Засгийн газраас бүх талаар дэмжин ажиллаж байна. Тухайлбал, 2020 оноос хойших хугацаанд Зэвсэгт хүчний Агаарын цэрэг 7, Хил хамгаалах Ерөнхий газар 1, Онцгой байдлын Ерөнхий газар 4 нэгж агаарын хөлгөөр хүчин чадлаа нэмэгдүүлсэн.

Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгжилтийг хангах, холбогдох хууль тогтоомжтой нийцүүлэн боловсронгуй болгож, зарим эрх зүйн харилцааг нарийвчлан тодорхойлох замаар хуулийг илүү боловсронгуй болно.

Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулиудад улсын агаарын хөлөг эзэмшигч байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулахтай холбогдсон харилцааг тухайлан тусгаагүй байсныг хуулийн төслөөр Улсын Их Хурал, Засгийн газрын бүрэн эрхэд улсын нисэхийн үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн орчныг боловсронгуй болж;

Улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагууд шинэ төрлийн агаарын хөлгөөр нислэгийн үйл ажиллагаа эрхлэх, үйл ажиллагаандаа олон улсын эрх бүхий байгууллагаас гэрчилгээжсэн гадаадын иргэн болон Монгол Улсын иргэний нисэх, бусад хувийн нисэхийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуй нэгж, иргэдтэй хамтран ажиллах болсон нь хүчин төгөлдөр мөрдөж байгаа Улсын нисэхийн тухай хуульд энэ талаарх тусгайлсан эрх зүйн зохицуулалт дутмаг байгааг засаж, энэ талаар эрх зүйн зохицуулалтыг хуульд тусгайлан шинээр нэмж;

Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад улсын нисэхийн асуудал хариуцсан бүтцийн нэгж шинээр бий болсонтой холбоотойгоор хуульд улсын агаарын хөлгийн бүртгэл, нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгох, цуцлах, сунгах болон нисэх, инженер техникчдийн бүрэлдэхүүнд нисэхийн мэргэжлийн үнэмлэх, зэрэглэл, зэрэг олгох, сунгах, батламжлах болон агаарын хөлгийг даатгалд хамааруулахтай холбогдсон харилцааг хуулиар тодорхой зохицуулалттай болж;

Улсын нисэхийн тухай хуулиар нислэгийн ангиллыг “байлдааны үүргийн нислэг”, “онцгой үүргийн нислэг”, “тусгай үүргийн нислэг”, “арилжааны нислэг”, “сургууль-байлдааны нислэг”, “шалгалт, туршилтын нислэг” гэж ангилсан бөгөөд улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагуудын гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагааны онцлогоос шалтгаалж “сургууль-дадлагын”, “олон улсын”, “албан захиалгат” нислэгийн ангиллыг нэмж тусгаагүй байсан.

Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсанаар улсын нисэхийн үйл ажиллагаа, түүний удирдлага, чиг үүрэг тодорхой болж, хуулийг зөв ойлгомжтой хэрэглэх, хуулийг хэрэгжүүлэх бусад эрх зүйн баримт бичгүүд боловсронгуй болж, давхцал, хийдэл бүрэн арилах боломж бүрдэнэ.

3.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

№	Практикт хэрэгжих боломж	Хуулийн төслийн холбогдох зохицуулалт
1	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээд байгаа эсэх, тэдгээр этгээдэд тухайн хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломжтой эсэх	<p>5.1. Улсын Их Хурал улсын нисэхийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>5.1.1. улсын нисэхийн салбарыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох;</p> <p>5.1.2. улсын нисэхийн тухай хууль тогтоомжийг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих;</p> <p>5.1.3. хуульд заасан бусад бүрэн эрх.</p> <p>6.1. Засгийн газар нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>6.1.1. улсын нисэхийг хөгжүүлэх талаарх бодлого, арга хэмжээг зохион байгуулах, улсын нисэхийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;</p> <p>6.1.2. улсын нисэхийн эрэн хайх, аврах үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээг чиглүүлэх;</p> <p>6.1.3. улсын нисэхийн аэродром байгуулах, өөрчлөх, шилжүүлэх, бэлэн байдал, түүнд тавигдах шаардлагыг тогтоох;</p> <p>6.1.4. улсын агаарын хөлөг, хөдөлгүүр болон газар дээрх дадлагажуур, тэдгээрийн эд анги, бүрэлдэхүүн хэсэг, дэд угсралтын хэсэг, сэлбэг, тоног төхөөрөмж, холбогдох хэрэгслийг гаалийн татвараас чөлөөлөх журмыг батлах;</p> <p>6.1.5. Улсын нисэхийн нисгэгч, инженер техникчид болон нисэхийн тусгай мэргэжлийн бүрэлдэхүүний жагсаалт, цалингийн хэмжээ, итгэлцүүрийг тогтоох.</p> <p>7.1. Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>7.1.1. улсын нисэхийн нислэгийн үйл ажиллагааны журмыг холбогдох байгууллагатай зөвшилцөж батлах;</p> <p>7.1.3. улсын нисэхийн багц дүрмийг батлах;</p>

		<p>7.1.4.улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ерөнхий шинжээчийг томилно;</p> <p>7.1.5 Улсын нисэхийн байцаагчийн эрх олгох;</p> <p>7.1.6 Улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагын нисгэгч, нисэхийн тусгай мэргэжлийн бүрэлдэхүүний хүнсний хангалтын тусгай нормыг тогтоох.</p> <p>8.1.Улсын нисэхийн үйл ажиллагаа Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хяналтад байна.</p> <p>8.2.Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь улсын нисэхийн үйл ажиллагааг хариуцсан бүтцийн нэгжтэй байна.</p> <p>8.3.Улсын нисэхийн хяналт зохицуулалтыг тасралтгүй, үр дүнтэй хэрэгжүүлэхэд нисэхийн мэргэжлээр бэлтгэгдсэн хүний нөөцийн чадавхтай байна.</p> <p>8.4.Улсын нисэхийн үйл ажиллагааг хариуцсан бүтцийн нэгж нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>8.4.1.улсын нисэхийн аюулгүй байдал, аюулгүй хамгаалалттай холбоотой хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх;</p> <p>8.4.2.улсын нисэхийн аюулгүй байдал, аюулгүй хамгаалалттай холбоотой мэдээллийн санг хөтлөх, холбогдох байгууллагуудтай мэдээлэл солилцох;</p> <p>8.4.3.улсын агаарын хөлөг, түүний бүрдэл хэсгийн гэрчилгээ, нисэхийн мэргэжлийн үнэмлэх, гэрчилгээ, зэрэг, зэрэглэл олгох, түдгэлзүүлэх, цуцлах;</p> <p>8.4.4.улсын нисэхийн дүрэм болон бусад холбогдох эрх зүйн актыг боловсруулах, батлуулах, бүртгүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;</p> <p>8.4.5.нислэгийн аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй Улсын нисэхийн дүрмээр зохицуулагдаагүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд тодорхой хугацаатай шийдвэр гаргаж, холбогдох этгээдэд мэдээлэх;</p>
--	--	--

	<p>8.5.Нислэгт тэнцэх чадварын гэрчилгээний хугацаа дууссан, нислэгт тэнцэх чадвараа алдсан агаарын хөлгийн нислэгийг зогсоох, зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох;</p> <p>8.6.Хуульд заасан бусад.</p> <p>9.1.Цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:</p> <p>9.1.1.байлдааны үүргийн, сургууль-байлдааны үүргийн нислэгийг төлөвлөх, гүйцэтгэх;</p> <p>9.1.2.онцгой үүргийн нислэгийн зөвшөөрөл олгох, нислэгийн хөдөлгөөнд хяналт тавина;</p> <p>9.1.3.хилийн агаарын бүсэд нислэг үйлдэх зөвшөөрөл олгох;</p> <p>9.1.4.агаарын зайг нисэхэд ашиглах тухай хуулийн 7.1-т заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх;</p> <p>9.1.5.хуульд заасан бусад.</p>
--	--

3.3.“Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг хуулийн төсөлд бүхэлд нь дүн шинжилгээ хийж, үр нөлөөг тооцно. (Хуулийн төсөл 9 бүлэг, 27 зүйл).

Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-д заасан хуулийн төсөл боловсруулахад тавигдах нийтлэг шаардлагыг тус тус хангасан гэж үзэв.

3.4.“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

Хуулийн төслийн зүйл, заалтуудыг үзэхэд уялдаа, холбоог тодорхойлсон байна.

Хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт өөр хоорондоо болон Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын батлан хамгаалах тухай хууль, Зэвсэгт хүчний тухай хууль, Цэргийн албаны тухай хууль, Хууль тогтоомжийн тухай хууль болон бусад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжтой зөрчилдөөгүй, үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтны чиг үүрэгт давхардал үүсээгүй байна.

№	Асуулт	Хариулт	Дүн шинжилгээ
1.	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Тийм	Нийцсэн

2.	Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;	Тийм	Нийцсэн
3.	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх;	Тийм	Нийцсэн
4.	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Тийм	Нийцсэн
5.	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	Үгүй	Давхардаагүй
6.	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;	Тийм	Тусгасан
7.	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Үгүй	Орхигдуулаагүй
8.	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Үгүй	Давхардаагүй
9.	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Үгүй	Тусгаагүй
10.	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Үгүй	Тусгаагүй
11.	Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	Үгүй	Тусгаагүй
12.	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Үгүй	Хязгаарлаагүй
13.	Хуулийн төслийн зүйл, заалт жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	Үгүй	Хөндөөгүй
14.	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй	Тусгаагүй
15.	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй	Тусгаагүй

16.	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Тийм	Тусгаагүй
-----	--	------	-----------

Дөрөв. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгөх

Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үр нөлөөг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”-ын дагуу тооцож дараах дүгнэлт, зөвлөмжийг гаргаж байна.

Үр нөлөөний үнэлгээг хуулийн төсөлд хийхэд сонгосон 4 шалгуур үзүүлэлтүүдээр хуулийн төслийн үзэл баримтлалд заасан зорилгыг хангасан, практикт хэрэгжих боломжтой, хуулийн төслийн томъёолол, зохицуулалт, найруулга нь ойлгомжтой, хоёрдмол утга санаа илэрхийлээгүй, Монгол Улсын Үндсэн хууль, бусад холбогдох хууль тогтоомж болон тухайн хуулийн зүйл, заалттай давхардаагүй, зөрчилдөөгүй гэж дүгнэж байна.

Иймд холбогдох аргачлалд заасны дагуу Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, уялдаа холбоо хангагдсан гэж үзлээ.

Тус үр нөлөөг тооцох үнэлгээг Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын хүрээнд хийв.

---oOo---

УЛСЫН НИСЭХИЙН ТУХАЙ ХУУЛЬ
/ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙН ТӨСЛИЙН
ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

ТАЙЛАН

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 74-т “Улсын нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг боловсруулж, 2025 онд хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр заасан.

Улсын Их Хурлаас Улсын нисэхийн тухай хуулийг анх 2003 онд баталж, нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, бусад хууль тогтоомжид нийцүүлэн 2004, 2013, 2015, 2018 болон 2023 онд тус тус нэмэлт, өөрчлөлт оржээ.

Хууль тогтоомжийн тухай хуулийн холбогдох эрх зүйн зохицуулалтуудыг удирдлага болгон Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан ба улсын төсвөөс гарах зардлыг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-д үндэслэсэн.

Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог аргачлалын дагуу тооцох судалгааны зорилго нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, төрийн байгууллагад үүсэх зардлын ачааллыг тооцож, цаашид гарах ачааллыг багасгах санал боловсруулахад оршино.

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцоход дор дурдсан нийтлэг зарчмыг баримталсан. Үүнд:

- Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг нэг бүрийг оновчтой тодорхойлох;
- Үүрэг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг тогтооход бодитой хандах;
- Бодит тоо баримт, мэдээлэлд тулгуурлах;
- Аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах зэрэг юм.

Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 6.1.4-т “улсын агаарын хөлөг, хөдөлгүүр болон газар дээрх дадлагажуур, тэдгээрийн эд анги, бүрэлдэхүүн хэсэг, дэд угсралтын хэсэг, сэлбэг, тоног төхөөрөмж, холбогдох хэрэгслийг гаалийн татвараас чөлөөлөх журмыг батлах”, 6.1.5-д “Улсын нисэхийн нисгэгч, инженер техникчид болон нисэхийн тусгай мэргэжлийн бүрэлдэхүүний жагсаалт, цалингийн хэмжээ, итгэлцүүрийг тогтоох” гэж Засгийн газрын бүрэн эрхэд тус тус заасан.

Дээр дурдсан зохицуулалтыг хэрэгжүүлэхэд төсөвт нэмэлт зардал гарахгүй бөгөөд батлан хамгаалах салбарын батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна.

Өөрөөр хэлбэл Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 20.1-д “Батлан хамгаалах үйл ажиллагааг улсын төсвөөс санхүүжүүлнэ.”, Зэвсэгт хүчний тухай хуулийн 18.1-д “Зэвсэгт хүчнийг улсын төсвөөс санхүүжүүлнэ.” гэж заасны дагуу Монгол Улсын Үндсэн хуулийн Арван нэгдүгээр зүйлийн 1-д “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн”, мөн зүйлийн 2-т “Монгол Улс өөрийгөө хамгаалах зэвсэгт хүчинтэй байна. Зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалт, түүнд алба хаах журмыг

хуулиар тогтооно.”, Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 6 дахь заалтад “улсыг батлан хамгаалах хүчин чадлыг бэхжүүлж, үндэсний аюулгүй байдлыг хангах” гэж, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Тавдугаар зүйлийн Зорилт 5.2-т “Төрийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тодорхойлох замаар чиг үүрэг, эрх мэдлийн хуваарилалтыг нарийвчилна” гэсэн зохицуулалтуудыг бүрэн хэрэгжүүлэх юм.

Хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэрэгжүүлэхэд улсын төсөвт ямар нэмэлт зардал үүсэхгүй болно.

---oOo---

**“УЛСЫН НИСЭХИЙН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА-ЫН ТӨСӨЛД”
ТӨРИЙН БОЛОН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА, ОЛОН НИЙТЭЭС ИРҮҮЛСЭН САНАЛЫН ТОВЧОО**

№	БАЙГУУЛЛАГА, ИРГЭН	Засгийн газрын тогтоолын төсөлд өгсөн санал	Тайлбар, төсөлд тусгасан байдал
16.	Зэвсэгт хүчний Жанжин штаб	<p>Батлан хамгаалах сайдын 2025 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/12 дугаар тушаалаар томилогдсон Ажлын хэсгийн боловсруулж буй Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгах саналыг хүргүүлж байна.</p> <p>1.Хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалтын “..., шилжүүлэх бэлэн байдал, түүнд тавигдах шаардлагыг тогтоох,” гэснийг “..., татан буулгах,” гэж, -хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.1 дэх заалтын “...зөвшөөрөл олгоно” гэснийг “...зөвшөөрөлд хяналт тавих,” гэж, -хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.6 дахь заалтыг “Зөвшөөрлийн тухай хуулийн 10.14-т заасан зөвшөөрөл олгох.” гэж, -Хуулийн төслийн 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсгийн “... шинжлэн шалгагчийг ...” гэснийг “.. шинжлэн шалгах шинжээчийг ...” гэж тус тус өөрчилсөн;</p> <p>2.Хуулийн төслийн 8 дугаар зүйлийг “8 дугаар зүйл. Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг 8.1.Улсын нисэхийн үйл ажиллагаа Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хяналтад байна. 8.2. Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 8.2.1.улсын нисэхийн талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах; 8.2.2.улсын нисэхийн хяналт зохицуулалтыг тасралтгүй, үр дүнтэй хэрэгжүүлэхэд нисэхийн мэргэжлээр бэлтгэгдсэн хүний нөөцийн чадавхыг бүрдүүлэх. 8.2.3.улсын нисэхийн аюулгүй байдал, мэдээллийн санг хөтлөх, холбогдох байгууллагуудтай мэдээлэл солилцох; 8.2.4.улсын агаарын хөлөг, түүний бүрдэл хэсгийн гэрчилгээ, нисэхийн мэргэжлийн үнэмлэх, гэрчилгээ, зэрэг, зэрэглэл олгох, түдгэлзүүлэх, цуцлах;</p>	<p>1.Хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалтын “..., шилжүүлэх бэлэн байдал, түүнд тавигдах шаардлагыг тогтоох,” гэснийг “..., шилжүүлэх, татан буулгах,” гэж, -хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.1 дэх заалтын “...зөвшөөрөл олгоно” гэснийг “...зөвшөөрөлд хяналт тавих,” гэж, -хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.6 дахь заалтыг “Зөвшөөрлийн тухай хуулийн 10.14-т заасан зөвшөөрөл олгох.” гэж, -Хуулийн төслийн 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсгийн “... шинжлэн шалгагчийг ...” гэснийг “.. шинжлэн шалгах шинжээчийг ...” гэж тус тус өөрчилсөн;</p> <p>2. Хуулийн төслийн 8 дугаар зүйлийг “8 дугаар зүйл. Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг 8.1.Улсын нисэхийн үйл ажиллагаа Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хяналтад байна. 8.2. Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 8.2.1.улсын нисэхийн талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах; 8.2.2.улсын нисэхийн хяналт зохицуулалтыг тасралтгүй, үр дүнтэй хэрэгжүүлэхэд нисэхийн мэргэжлээр бэлтгэгдсэн хүний нөөцийн чадавхыг бүрдүүлэх. 8.2.3.улсын нисэхийн аюулгүй байдал, мэдээллийн санг хөтлөх, холбогдох байгууллагуудтай мэдээлэл солилцох; 8.2.4.улсын агаарын хөлөг, түүний бүрдэл хэсгийн гэрчилгээ, нисэхийн мэргэжлийн үнэмлэх, гэрчилгээ, зэрэг, зэрэглэл олгох, түдгэлзүүлэх, цуцлах;</p>

	<p>8.2.5.Улсын нисэхийн багц дүрэм болон бусад холбогдох эрх зүйн актыг боловсруулах, батлуулах, бүртгүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;</p> <p>8.2.6.нислэгт тэнцэх чадварын гэрчилгээний хугацаа дууссан, нислэгт тэнцэх чадвараа алдсан агаарын хөлгийн нислэгийг зогсоох, зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох;</p> <p>8.2.7.улсын нисэхийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалттай холбоотой хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх;</p> <p>8.2.8.нислэгийн аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй Улсын нисэхийн багц дүрмээр зохицуулагдаагүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд тодорхой хугацаатай шийдвэр гаргах, холбогдох этгээдэд мэдээлэх;</p> <p>8.3.Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь улсын нисэхийн үйл ажиллагааг хариуцсан бүтцийн нэгжтэй байна.</p> <p>3.Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Улсын нисэхийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийг тус хуулийн төслийн 16 дугаар зүйлд “16.2.Цэргийн зориулалтай нисэхийн аэродром байгуулах, өөрчлөх, шилжүүлэх, татан буулгах, түүний бэлэн байдал, түүнд тавигдах шаардлагыг тогтоох асуудлыг цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллагын санал болгосноор Зэвсэгт хүчний ерөнхий командлагчтай зөвшилцөн Засгийн газар шийдвэрлэнэ.” гэсэн хэсэг болгон нэмэх;</p> <p>4.Хуулийн төслийн 23, 24 дүгээр зүйлд Улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шалгах ерөнхий шинжээч (байцаагч)-ийн бүрэн эрх болон түүний үүргийг тус тусд нь зохицуулсан байх тул нэг зүйл болгон нэгтгэх саналтай байна. (2025.08.07-ны өдрийн 02/2439 дугаар албан бичиг)</p>	<p>санг хөтлөх, холбогдох байгууллагуудтай мэдээлэл солилцох;</p> <p>8.2.4.улсын агаарын хөлөг, түүний бүрдэл хэсгийн гэрчилгээ, нисэхийн мэргэжлийн үнэмлэх, гэрчилгээ, зэрэг, зэрэглэл олгох, түдгэлзүүлэх, цуцлах;</p> <p>8.2.5.Улсын нисэхийн багц дүрэм болон бусад холбогдох эрх зүйн актыг боловсруулах, батлуулах, бүртгүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;</p> <p>8.2.6.нислэгт тэнцэх чадварын гэрчилгээний хугацаа дууссан, нислэгт тэнцэх чадвараа алдсан агаарын хөлгийн нислэгийг зогсоох, зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох;</p> <p>8.2.7.улсын нисэхийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалттай холбоотой хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх;</p> <p>8.2.8.нислэгийн аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй Улсын нисэхийн багц дүрмээр зохицуулагдаагүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд тодорхой хугацаатай шийдвэр гаргах, холбогдох этгээдэд мэдээлэх;</p> <p>8.3.Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь улсын нисэхийн үйл ажиллагааг хариуцсан бүтцийн нэгжтэй байна.” гэж өөрчлөн найруулсан.</p> <p>3. Хуулийн төслийн 16 дугаар зүйлд “16.2.Цэргийн зориулалтай нисэхийн аэродром байгуулах, өөрчлөх, шилжүүлэх, татан буулгах, түүний бэлэн байдал, түүнд тавигдах шаардлагыг тогтоох асуудлыг цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллагын санал болгосноор Зэвсэгт хүчний ерөнхий командлагчтай зөвшилцөн Засгийн газар шийдвэрлэнэ.” гэсэн хэсэг нэмсэн.</p> <p>4.Хуулийн төслийн 24 дүгээр зүйлийг 23 дугаар зүйлд “23 дугаар зүйл. Улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шалгах ерөнхий шинжээч (байцаагч)-ийн бүрэн эрх, чиг үүрэг</p>
--	--	---

23.1.Улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шалгах ерөнхий шинжээч нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

23.1.1.албан үүргээ гүйцэтгэхдээ улсын нисэхийн үйл ажиллагаатай холбоотой газруудад саадгүй нэвтрэх;

23.1.2.шинжлэн шалгах ажиллагаанд шаардлагатай мэдээ, судалгаа, тодорхойлолт болон бусад нотлох баримтыг холбогдох хүн, хуулийн этгээдээс шаардан авах;

23.1.3.Улсын нисэхийн багц дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргах;

23.1.4.улсын агаарын хөлгийн эзэмшигч байгууллагын нислэгийн бэлтгэл, гүйцэтгэлд үнэлэлт өгөх;

23.1.5.улсын нисэхийн техникийн ашиглалтын горимд хяналт тавьж дүгнэлт гаргах, зөвлөмж өгөх;

23.1.6.улсын агаарын хөлгийн нислэг-техникийн осол, зөрчлийн шалтгааныг үнэн зөв тогтоох, шаардлагатай мэдээ, судалгаа, бусад баримт бичгийг холбогдох этгээдээс шаардан гаргуулж авах.

23.2.Улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шалгах ерөнхий шинжээч нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

23.2.1.улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааг зохион байгуулах;

23.2.2.улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах, ангилах, бүртгэх ажиллагааг гүйцэтгэх;

23.2.3.улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах комиссын дүрмийг батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр батлуулах;

23.2.4.улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах комисс томилуулах тухай саналаа батлан хамгаалах

		<p>асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулж, шийдвэрлүүлэх; 23.2.5.улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчилтэй холбоотой мэдээллийг цуглуулан дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөл, нөлөөлсөн хүчин зүйлсийн талаар тайлан гаргах.” гэж нэгтгэсэн.</p>
<p>17. Батлан хамгаалах яамны ахмадын хороо</p>	<p>Таны 2025 оны 1в/2873 дугаар албан бичгээр ирүүлсэн “Улсын нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” албан бичигтэй танилцаад дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:</p> <p>1.Хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.3, 14.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах; -13.3.Агаарын хөлгийн дарга нь нислэгийн аюулгүй байдалд илт аюул тулгарсан, аюул тулгарах нь тодорхой болсон тохиолдолд Улсын агаарын хөлөг болон түүний бүхээгт байгаа хүмүүсийн амь насыг аврах зорилгоор нислэгийн төлөвлөгөө болон нислэгийн хөдөлгөөний удирдагч /удирдлага/-ийн өгснөөс шийдвэр гаргах эрхтэй; -13.4.Агаарын хөлгийн дарга нь энэ хуулийн 14.1.1-т зааснаас бусад нислэгийг гүйцэтгэх үед Иргэний нисэхийн тухай хуулийн 21.3-т заасан эрхийг хэрэгжүүлнэ.</p> <p>2.Хуулийн төслийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсгийн “Энэ хуулийн 15.1.1, 15.1.2, 15.1.3-д зааснаас бусад ..” гэснийг “Энэ хуулийн 15.1.4-15.1.8-д заасан ..” гэж өөрчлөх;</p> <p>3.Хуулийн төслийн 2 дугаар зүйлийн 2.1-д “..Үндсэн хууль...” гэж нэмэх;</p> <p>4.Хуулийн төслийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсгийн “..батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, иргэний нисэхийн төрийн захиргааны төв байгууллагын..” гэснийг “энэ хуулийн 7.1.4-т заасан ..” гэж өөрчлөх;</p> <p>5.Хуулийн төслийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийн “...төрийн захиргааны төв байгууллагын ...” гэснийг “... батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ...” гэж өөрчлөх зэрэг болно.</p>	<p>1.Хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.3, 13.4 дэх заалтыг “13.3.Агаарын хөлгийн дарга нь нислэгийн аюулгүй байдалд илт аюул тулгарсан, аюул тулгарах нь тодорхой болсон тохиолдолд Улсын агаарын хөлөг болон түүний бүхээгт байгаа хүмүүсийн амь насыг аврах зорилгоор нислэгийн төлөвлөгөө болон нислэгийн хөдөлгөөний удирдагч /удирдлага/-ийн өгснөөс өөр шийдвэр гаргах эрхтэй,” гэж, “13.4.Агаарын хөлгийн дарга нь энэ хуулийн 14.1.1-т зааснаас бусад нислэгийг гүйцэтгэх үед Иргэний нисэхийн тухай хуулийн 21.3-т заасан эрхийг хэрэгжүүлнэ.” гэж тус тус өөрчлөн найруулсан; 2.Хуулийн төслийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсгийн “Энэ хуулийн 15.1.1, 15.1.2, 15.1.3-д зааснаас бусад ..” гэснийг “Энэ хуулийн 15.1.4-15.1.8-д заасан ..” гэж өөрчилсөн; 3. Хуулийн төслийн 2 дугаар зүйлийн 2.1-д “..Үндсэн хууль...” гэж нэмсэн. 4. Хуулийн төслийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсгийн “..батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, иргэний нисэхийн төрийн захиргааны төв байгууллагын..” гэснийг “энэ хуулийн 7.1.4-т заасан ..” гэж, мөн төслийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийн “...төрийн захиргааны төв байгууллагын ...” гэснийг “... батлан хамгаалах</p>

	(2025.08.11-ний өдрийн 25 дугаар албан бичиг)	асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ..." гэж тус тус өөрчилсөн.
18.	<p>Таны 2025 оны 1в/2873 дугаар албан бичгээр ирүүлсэн "Улсын нисэхийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" албан бичигтэй танилцлаа. Хуулийн төслийг дэмжихийн зэрэгцээ дараах саналуудыг хүргүүлж байна. Үүнд:</p> <p>Хуулийн төслийн 9 дүгээр зүйлд "зөвшөөрлийн тухай хуулийн 10.14-т заасан зөвшөөрлийг олгох" гэж нэмэх</p> <p>Хуулийн төслийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн "Байлдааны болон сургууль байлдааны үүргийн .." гэснийг "Энэ хуулийн 14.1.1, 14.1.5-д заасан нислэгийг .." гэж өөрчлөн найруулах</p> <p>Хуулийн төслийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн "...агаарын хөлгүүд.." гэснийг "...нисэхийн зориулалтаар .." гэж өөрчлөх</p> <p>Хуулийн төслийн 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсгийн "...засаг захиргаа, аж ахуйн нэгж.." гэснийг "засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, аж ахуйн нэгж.." гэж өөрчлөн найруулах</p> <p>Хуулийн төслийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн ".. Төрийн албаны тухай хуульд заасан .." гэснийг ".. Төрийн албаны тухай хууль болон Цэргийн албаны тухай хуульд заасан .." гэж өөрчлөх</p>	<p>Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.6-д "Зөвшөөрлийн тухай хуулийн 10.14-т заасан зөвшөөрлийг олгох;" гэсэн заалт нэмсэн;</p> <p>Хуулийн төслийн 14 дугаар зүйлийн 14.2 дахь хэсгийн "Байлдааны болон сургууль байлдааны үүргийн .." гэснийг "Энэ хуулийн 14.1.1, 14.1.5-д заасан нислэгийг .." гэж, мөн төслийн 17 дугаар зүйлийн 1.1 дэх хэсгийн "... агаарын хөлгүүд ..." гэснийг "...нисэхийн зориулалтаар .." гэж, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийн ".. Төрийн албаны тухай хуульд заасан .." гэснийг ".. Төрийн албаны тухай хууль болон Цэргийн албаны тухай хуульд заасан .." гэж тус тус өөрчилсөн;</p> <p>/Хуулийн төслийн 15 дугаар зүйлийг 10 дугаар зүйлтэй нэгтгэсэн тул зүйлүүдийн дугаарлалт өөрчлөгдсөн болно./</p>
19.	<p>Сайн байна уу?</p> <p>Улсын нисэхийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж байгааг дэмжиж байна.</p> <p>Би цэргийн нисэхэд амьдралаа зориулж гавьяаныхаа амралтад гарсан хүн байгаа юмаа.</p> <p>Хуулийн төсөлд Улсын нисэхийн багц дүрмийг нэр томъёоны тодорхойлолтод тусгавал зүгээр санагдлаа.</p>	<p>Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.15-д "Улсын нисэхийн багц дүрэм" гэж тусгасан.</p>
20.	<p>Иргэн С.Баярхүү Baytulu690@gmail.com</p>	<p>Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг "Улсын агаарын хөлгийн нислэгийн хөдөлгөөнд хяналт тавих" гэж өөрчлөн найруулсан.</p>
21.	<p>Алба хаагч С.Ганбат saneregganbat@gmail.com</p>	<p>Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.15-д "Улсын нисэхийн багц дүрэм" гэж тусгасан.</p>
22.	<p>Алба хаагч Э.Будрагчаа budragchaa@intemet.ru</p>	<p>Хуулийн төсөлд тухайн чиглэлээр зохицуулалтыг нэмэгдүүлэхгүй, "Улсын нисэхийн багц дүрэм"-ийн 2 дугаар хавсралт болох "Нисэхийн мэргэжлийн үнэмлэх, зэрэг, зэрэглэл, эрүүл</p>

		<p>Гэрчилгээжүүлэлт системд дижитал хандалт, QR, цахим баталгаажуулалт нэвтрүүлэх.</p>	<p>мэндийн гэрчилгээ олгох, сунгах, түдгэлзүүлэх, цуцлах дүрэм"-д тусгах нь зүйтэй гэж үзсэн.</p>
<p>23.</p>	<p>Иргэн У.Нарангарав Munkhorgil13021 9@gmail.com</p>	<p>Амрыг эрье! Би агаарын цэргийн ангийн алба хаагч энэ газраас ажил амьдралаа эхлүүлж 10аад жил болсон байна. Тийм ч учраас энэ салбартаа бүх сэтгэлээ зориулж ажилдаг бөгөөд нисэхийн салбар маань улам их хөгжиж сайн сайхан болоосой бусад улсын нисэхийн салбараас битий дутаасай гэж боддог. Тиймээс та бүхний хийж байгаа улсын нисэхийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж байгааг дэмжиж байгаа бөгөөд тэдгээр өөрчлөлтүүд бидэнд тулгамдсан асуудлуудыг шийдэхэд сайнаар нөлөөлж цаашид хэрэгтэй гэж бодож байна. Та бүхний ажилд амжилт хүсье. Хөх тэнгэр нь цэлмэг байг.</p>	<p>Хуулийн төслийг дэмжсэн.</p>

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ

УЛСЫН НИСЭХИЙН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА-ИЙН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

2025-08-01

83



Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 74-т “Улсын нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг боловсруулж, 2025 онд хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх гэж заасныг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Улсын нисэхийн тухай хууль / шинэчилсэн найруулга/-ийн төслийн боловсруулан холбогдох хууль эрх зүйн хүрээнд төслийн бүрдүүлбэрийг ханган ажиллаж байна.



**ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБ
АХМАДЫН ХОРОО**

13340 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энхтайваны өргөн чөлөө 51,
Утас: 9908 0030, Факс: (976) 7015 2429,
Э-мэйл: akhmadkhoroo@gmail.com

**БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
ХОШУУЧ ГЕНЕРАЛ Д.ГАНХУЯГ
ТАНАА**


2025.08.14 № 27
танай _____-ны № _____-т

Санал хүргүүлэх тухай

Таны 2025 оны 1в/2873 дугаар албан бичгээр ирүүлсэн “Улсын нисэхийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” албан бичигтэй танилцлаа. Хуулийн төслийг дэмжихийн зэрэгцээ дараах саналуудыг хүргүүлж байна. Үүнд:

- Хуулийн төслийн 9 дүгээр зүйлд “зөвшөөрлийн тухай хуулийн 10.14-т заасан зөвшөөрлийг олгох” гэж нэмэх;
- Хуулийн төслийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн “Байлдааны болон сургууль байлдааны үүргийн ..” гэснийг “Энэ хуулийн 14.1.1, 14.1.5-д заасан нислэгийг ..” гэж өөрчлөн найруулах
- Хуулийн төслийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн “..агаарын хөлгүүд..” гэснийг “..нисэхийн зориулалтаар ..” гэж өөрчлөх
- Хуулийн төслийн 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсгийн “..засаг захиргаа, аж ахуйн нэгж..” гэснийг “засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, аж ахуйн нэгж..” гэж өөрчлөн найруулах
- Хуулийн төслийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн “.. Төрийн албаны тухай хуульд заасан ..” гэснийг “.. Төрийн албаны тухай хууль болон Цэргийн албаны тухай хуульд заасан ..” гэж өөрчлөх зэрэг болно.

ДАРГА  Д.БАДАМ



С.Билэгбаяр
УНХ



**УЛСЫН НИСЭХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН
ТӨСЛИЙГ УИХ-ЫН ЧУУЛГАН БОЛОН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНААР
ХЭЛЭЛЦҮҮЛЭХЭД ОРОЛЦОХ АЛБАН ТУШААЛТНУУДЫН НЭР**

Д/д	Цол	Овог, нэр	Албан тушаал	Утас
1.	-	Дамбын Батлут	Батлан хамгаалахын сайд	99051314
2.	Дэслэгч генерал	Сүнрэвийн Ганбямба	Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга	99261912
3.	Хошууч генерал	Давагдоржийн Ганхуяг	Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга	99091170
4.	Хурандаа	Эрхэмбаярын Гансүх	Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга	99088956
5.	Хурандаа	Пүрэвдоржийн Идэр	Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Улсын нисэхийн хэлтсийн дарга	88087731
6.	-	Гомбосүрэнгийн Энхболд	Батлан хамгаалах яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Ахлах шинжээч, хуулийн зөвлөх	96654413

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР